**“ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛ БА МХТ-ИЙН ХЭРЭГЛЭЭ”**
**ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА**

## *Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ*

### *1. Хичээлээр эзэмших мэдлэг, чадвар, хандлага (CLO):*

1.1. Тэгш хамруулсан сургууль, анги дахь МХТ, сонсголын, хэл ярианы, харааны, суралцах бэрхшээлтэй сурагчийн МХТ-ийн дэмжих хэрэгслүүд, тэдгээрийн ангилал, ач холбогдлыг тайлбарлаж, тэдгээрийг үйл ажиллагаандаа хэрэглэдэг.

2.1. Сурагчийн өдөр тутмын үйл ажиллагааг дэмжих МХТ-ийн хэрэгсэл, орчны тохиргоог гүйцэтгэдэг.

2.2. Тусгай хэрэгцээт сурагчийн суралцахуйг дэмжих программуудыг ашиглаж, сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулдаг.

3.1. Тэгш хамруулах боловсролын хүртээмж, чанарыг сайжруулахад МХТ-ийн давуу талыг ашиглах чиглэлээр судалгаа хийх хүсэл эрмэлзэлтэй байх

3.2. Тэгш хамруулан сургах анги танхимд МХТ-ийн дэмжих технологиор дамжуулан суралцагчийн гүйцэтгэл, амжилт, бие даасан байдлыг дэмжих бололцоог эрэлхийлдэг байх

### 2. Үнэлгээний хэлбэр, жин

*Хүснэгт 1. Үнэлгээний хэлбэр ба багтаамж*

| № | Үнэлгээний хэлбэр | Эзлэх хувь | Багтаамж |
|---|---|---|---|
| 1 | Ирц, оролцоо | 20% | Ирц: 10 % Лекц семинарын хичээлд ирсэн байдал<br>Оролцоо: 10 % Семинарын тэмдэглэл, багийн ажлын оролцоо, хэлэлцүүлэг удирдсан, асуултад хариулсан байдал зэргийг харгалзан үнэлнэ. |
| 2 | Бие даах ажил | 30% | Бие даах ажлыг хийж гүйцэтгэсэн байдал<br>i. Судалсан эх сурвалжийн сонголт болон сэдэвтэй уялдсан байдал<br>ii. Бичсэн ажлын ерөнхий бүтэц, агуулга, найруулга, үзэл санааны илэрхийлэл<br>iii. Бичлэгийн соёл<br>• Бичлэгийн техник, дизайн<br>• Эш авалт, зүүлт хийх |

| | | | |
|---|---|---|---|
| 3 | Явцын сорил, шалгалт | 20% | Хичээлийн агуулгын дагуу оюутны эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагад гарсан өөрчлөлтийг үнэлнэ. |
| 4 | Лабораторийн ажлууд | 20% | Лаборатори ажилд өгсөн даалгавруудын гүйцэтгэлээр үнэлэгдэнэ. |
| 5 | Улирлын шалгалт | 10% | Хичээлийн төгсгөлд тухайн хичээлийн хүрэх үр дүнгийн хэрэгжилтийг үнэлнэ. |

## ХОЁР. ХИЧЭЭЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**Хичээлийн нэр, код:** Тэгш хамруулах боловсрол ба Мэдээлэл харилцааны технологийн хэрэглээ
**Улирал**: Дурын
**Хичээлийн задаргаа**: 1:0:2:0(3) (Лекц: семинар: лаборатори: практик, бие даалт)
**Нийт цаг, кредит :** 48 цаг, 2 кредит
**Заах багш:** Л.Мөнхтуяа
**Утас:** 7777-5115 (1062)
**Ажлын өрөө:**
**Ажиллах цаг:** Даваа–Баасан, 9:00 am – 18:00 pm.
**ULMS хаяг:**

**Нэмэлт унших материалууд:**

Монгол улсын боловсролын салбар дахь Мэдээлэл харилцаа холбооны технологийн бодлогын тойм шинжилгээ ЮНЕСКО 2021 он

Кирсти Ньюман Монгол Улсад тэгш хамруулах боловсролыг дэмжих нь 2020 он
Д.Одгэрэл, Ч. Нямдорж Тэгш хамруулан сургах боловсролын үндэс 2022 он

https://www.european-agency.org/activities/ict4i
https://iite.unesco.org/
https://elibrary.iite.unesco.org/#/courseManagement/courseDetail/67317640-004a-46f0-a3c6-2ec580c4c90d
https://www.ictesolutions.com.au/blog/10-things-that-are-good-about-ict-in-an-earlychildhood-education-inclusive-classroom/
https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000378404
chrome extension://efaidnbmnnnibpcajpcglclefindmkaj/https://egyankosh.ac.in/bitstream/123456789/46322/1/Unit-15.pdf

**Хичээлийн өмнөх холбоо:**

**Хичээлийн товч тодорхойлолт:** Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч сургууль, анги танхимын орчинд өдөр тутмын үйл ажиллагаа болон сурах үйлдээ дэмжих технологийг

ашигласнаар хүртээмжтэй, тэгш оролцоотой байх боломжийг олгодог. Суралцагч ердийн анги танхимд суралцахын тулд суралцагчийн гүйцэтгэл, амжилт, бие даасан байдлыг дэмжих олон төрлийн дэмжих технологийн шийдлүүд байх ба Тэгш хамруулан сургах анги танхимд МХТ-ийн дэмжих хэрэгслийг оновчтой сонгон хэрэглэснээр хуртээмжтэй байдлыг нэмэгдүүлж, сургалтын чанарт ахиц гардаг.

Хичээлийн зорилго: Тусгай хэрэгцээт суралцагчийн анги танхим дахь оролцоо, амжилтыг нэмэгдүүлэхийн тулд МХТ-ийн төрөл бүрийн дэмжих хэрэгслийн шийдэл, сургалтад хэрэглэх арга зүйтэй танилцаж, практикт хэрэглэх чадвар эзэмшинэ.

**Хичээлийн агуулга:**
Тэгш хамруулсан сургууль, анги танхимд МХТ-ийн дэмжих хэрэгслийг мэдэх, хэрэглэх, сонсголын, хэл ярианы, харааны, суралцах бэрхшээлтэй сурагчийн МХТ-ийн дэмжих хэрэгслүүдийг мэдэх, хэрэглэх, төрөл бүрийн дэмжих программуудыг мэдэх, тэдгээрийг сургалтад үр бүтээлтэй хэрэглэх, тусгай хэрэгцээт сурагчийн компьютерын тохиргоо хийх, тусгай хэрэгцээт сурагчид тохируулан сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах боломжуудыг мэдэж хэрэглэх арга барилыг эзэмшинэ.

*Хүснэгт 2. Хичээлээр эзэмших мэдлэг, чадвар ба хичээлийн цөм агуулгын хамаарал*

| Хичээлийн цөм агуулга | Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадварууд |
|---|---|
| Тэгш хамруулах боловсрол ба МХТ-ийн дэмжлэг | 1.1; 3.1; |
| Сурах бэрхшээлийг дэмжих хүртээмжтэй МХТ-ийн хэрэгслүүд, үүрэг, хэрэглээ | 1.1; 3.2; |
| Сонсгол, хэл яриа, харааны бэрхшээлийг дэмжих МХТ-ийн хэрэгсэл, орчны тохиргоо | 1.1; 2.2; |
| Тусгай хэрэгцээт сурагчийн суралцахуйг дэмжих программуудыг мэдэх, тэдгээрийг сургалтад үр бүтээлтэй хэрэглэх, компьютерын тохиргоо хийх | 1.1; 2.1; 3.1; |
| Тусгай хэрэгцээт сурагчид тохируулан сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах боломжуудыг мэдэх, хэрэглэх | 1.1; 2.2; |

*Хүснэгт 3. Хичээлийн жишиг төлөвлөгөө*

| № | Модуль | Сэдэв | Лекц цаг | Лаб цаг |
|---|---|---|---|---|
| 1 | Тэгш хамруулах боловсрол ба МХТ-ийн дэмжлэг | Тэгш хамруулсан ангийн тухай ойлголт<br>Тэгш хамруулсан анги дахь МХТ-ийн үүрэг | 2 | 4 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Тэгш хамруулсан анги дахь МХТ-ийн хэрэглээ (OER) | | |
| 2 | Сурах бэрхшээлийг дэмжих хүртээмжтэй МХТ-ийн хэрэгсэлүүд, үүрэг, хэрэглээ | МХТ-ийн дэмжих технологийн ойлголт<br>МХТ-ийн дэмжих технологийн ангилал (Үндсэн технологи, Хүртээмжтэй формат, нэмэлт хэрэгсэл)<br>Тэгш хамруулсан ангид МХТ-ийн дэмжих технологийн хэрэглээ | 2 | 4 |
| 3 | Сонсголын бэрхшээлийг дэмжих МХТ-ийн хэрэгсэл, орчны тохиргоо | Сонсголын бэрхшээлийг дэмжих<br>- Орчны тохиргоо<br>- Программын хэрэгсэл<br>- Компьютерийн тохиргоо<br>- Сургалтын арга зүй<br>- Кэйстэй ажиллах | 2 | 4 |
| 4 | Хэл ярианы бэрхшээлийг дэмжих МХТ-ийн хэрэгсэл, орчны тохиргоо | Хэл ярианы бэрхшээлийг дэмжих<br>- Орчны тохиргоо<br>- Программын хэрэгсэл<br>- Компьютерийн тохиргоо<br>- Сургалтын арга зүй<br>- Кэйстэй ажиллах | 2 | 4 |
| 5 | Харааны бэрхшээлийг дэмжих МХТ-ийн хэрэгсэл, орчны тохиргоо | Харааны бэрхшээлийг дэмжих<br>- Орчны тохиргоо<br>- Программын хэрэгсэл<br>- Компьютерийн тохиргоо<br>- Сургалтын арга зүй<br>- Кэйстэй ажиллах | 2 | 4 |
| 6 | Тусгай хэрэгцээт сурагчийн суралцахуйг дэмжих программуудын харьцуулсан судалгаа | - Төрөл бүрийн дэмжих программууд, тэдгээрийн онцлог, жишээ<br>- Уг программыг сургалтад хэрэглэж буй туршлага | 2 | 4 |
| 7 | Программуудыг сургалтад үр бүтээлтэй хэрэглэх, компьютерийн тохиргоо хийх | - Сургалтад хэрэглэх арга зүй<br>- Компьютерийн тохиргоо | 2 | 4 |
| 8 | Тусгай хэрэгцээт сурагчид тохируулан сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах боломжуудыг мэдэх, хэрэглэх | - Сургалтын хэрэглэгдэхүүний онцлог<br>- Хэрэглэгдэхүүнд тавигдах шаардлага<br>- Хэрэглэгдэхүүнд тохиргоо хийх<br>- Тэгш хамруулсан анги танхим | 2 | 4 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | дахь сургалтын арга зүй | | |
| **Нийт цаг** | | | **16** | **32** |

**Хичээлийн арга зүй:** Суралцагчийн идэвх оролцоонд тулгуурласан, танхим болон цахимаар бие даан болон хамтран ажиллаж сурч хөгжих, тэдний бүтээлч үйлийг дэмжсэн суралцагч төвтэй арга зүйг баримтална.

**Хичээлийн үнэлгээ:**

- МУБИС-ийн сургалтын журмын харгалзах заалтуудыг баримтална.
- Суралцагч нэг бүрийн идэвх оролцоог тооцсон, суралцагчийн Мэдээллийн системийн талаарх хэрэглээний мэдлэг, чадвар, хандлагад гарч буй ахиц дэвшлийг МУБИС-ийн суралцагчийн үнэлэх журмын дагуу үнэлнэ.

**Хичээлд суусан/оролцсон байдлыг үнэлэх арга:**

- МУБИС-ийн сургалтын журмын харгалзах заалтуудыг баримтална.
- Үнэлгээний "Ирц, оролцоо" хэсэг нь 20 оноотой байх ба суралцагч нийт 48 цагийн хичээлд суусан эсэхээс хамаарч оноогоо цуглуулна.
- Үнэлгээний "Лабораторийн ажлууд" хэсэг нь 20 оноотой ба заавал тооцуулах лаборатори ажилд өгөгдсөн даалгавруудыг хийж, гүйцэтгэн тооцоолуулж харгалзах оноогоо авна.

**ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛ (P.IE306) ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА**

**Нэг: ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ**

**Хичээлээр эзэмших, мэдлэг, чадвар, хандлага (CLO):**

1.1. Хүүхэд нэг бүрийн онцлог, ялгаатай байдал, хэрэгцээ, чадварыг илрүүлэн таньдаг.

1.2. Тусгай хэрэгцээтэй хүүхдийг суралцахад нь тохиолдож буй бэрхшээл болон хүүхдэд байгаа нөөц боломж, давуу талыг илрүүлдэг.

2.1. Хүүхдийн хөгжлийн анхан шатны үнэлгээ хийх, дүгнэлт гаргах, олон хувилбартай үнэлгээний аргачлалыг хэрэглэж судалдаг.

2.2. Сургалтын хөтөлбөрт суралцагч нэг бүрийн суралцахуйг дэмжих, агуулга, арга зүй, хэрэглэгдэхүүний тохируулга хийж, сургалт үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулан туршиж үр дүнг тооцдог.

2.3. Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдийн эрхийг хүндэтгэн тэдний хөгжлийн давуу тал, нөөц боломжид тулгуурлан хөгжүүлэхэд бусадтай хамтран ажилладаг.

3.1. Суралцагч бүрийн хувийн онцлог, сонирхол, хэрэгцээ, ялгаатай байдлыг харгалзан сурч хөгжих эрхийг дээдэлдэг, хүндэтгэдэг, өөртөө итгэх итгэлийг төрүүлдэг.

3.2. Суралцагчийн хөгжлийг дэмжихэд эцэг эх, олон нийт, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах, тасралтгүй хөгжих дэмжихийг эрмэлздэг.

3.3. Боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдийн эцэг эх, гэр бүл, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллаж, тэднийг үйл ажиллагаанд татан оролцуулж дэмждэг.

3.4. Хүүхэд бүрийн ялгаатай байдлыг хүндэтгэх, багшийн ёс зүйтэй, тэднийг боловсролд тэгш хамруулан сургахад идэвх санаачилгатай ханддаг.

**Үнэлгээний хэлбэр, жин**

*Хүснэгт 1. Үнэлгээний хэлбэр ба багтаамж*

| № | Үнэлгээний хэлбэр | Эзлэх хувь | Багтаамж |
|---|---|---|---|
| 1 | Ирц, оролцоо | 15% | 1. Лекц болон семинарын хичээлийн ирцийг бүртгэж нийт 10%-аар тооцно.<br>2. Хичээл дэх оролцоог 5%-аар тооцно. |
| 2 | Бие даах ажил | 50% | Стандартад өгсөн 3 бие даах ажлаас хоёрыг сонгон гүйцэтгэнэ. |

| | | | |
|---|---|---|---|
| 3 | Явцын үнэлгээ | 35% | Хоёр удаагийн сорилоор явцын үнэлгээг хэрэгжүүлнэ. Эхний сорил 15, хоёр дахь сорил нийт 20 оноотой байна. |

**Хоёр: ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

**Хичээлийн нэр, код:** Тэгш хамруулах боловсрол
**Хичээлийн код:** P.IE306
**Судлах улирал:** Намар
**Хичээлийн задаргаа:** 2:2:0.0. 3 кредит (Лекц, семинар)
**Анги:**
**Заах багш:** Г.Батжаргал
**Е-майл хаяг:** gbatjargal@msue.edu.mn
**Утасны дугаар:** (976)- 88037898, 96674666
**Ажлын өрөө:** Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн 8-р байр 412 тоот
**Ажиллах цаг:** Даваа-Баасан 9:00 am-18:00 pm

**Үндсэн сурах бичиг:**

Наранцэцэг, Д., Батцэнгэл, Г., Гэрэлтуяа,Ц., Төртогтох,Б .,& Батжаргал,Г (2017). Тэгш хамруулах боловсролын чиг хандлага сургуулийн өмнөх боловсролд.Улаанбаатар

Одгэрэл. Д, Нямдорж. Ч., (2022) Тэгш хамруулан сургах боловсролын үндэс, 1 дэх хэвлэл, УБ Адмон ХХК

Candace Kaye, Marilyn Kaff, Kirsten McBridge, Randa G. Keeley, Lynette Bagwell (2018) Тусгай хэрэгцээт боловсролын үндэс УБ Мөнхийн үсэг ХХК

**Нэмэлт унших материалууд:**

Батцэнгэл,Г.,Гэрэлтуяа,Ц., бусад(2008) *Хөгжлийн бэрхшээлийг танин мэдэхүй*.Улаанбаатар

Батжаргал, Г.,(2019) *Анхаарлын дутмагшил, хэт хөдөлгөөнтэй хүүхдийн хөгжлийг дэмжих дасгал, тоглоом.* Улаанбаатар: Би Си Ай ХКК

Ишикура, К. (2010).Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах ажлын онол аргазүйн асуудал.Улааанбаатар:

Жанет Гонзалес-Мина (2016) Бага насны боловсролын үндэс. Улаанбаатар:

Кузнецова,Л.В.,(2006) *Основы специальной психологий.* Москва

МУБИС, Нагояа их сургууль(2016) *Боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхэдтэй ажиллах арга зүй /гарын авлага* /.Улаанбаатар

Травис Томпсон., (2008) *Аутизм ба амьдрал.* Улаанбаатар:

Туяа,Б.,Батцэнгэл,Г.,Одгэрэл,Д.,(2010). Тэгш хамруулан сургагч багш нарын боловсрол.Улаанбаатар

Туяа,Б.,Одгэрэл,Д.,Гэрэлтуяа,Ц.,Батцэнгэл,Г.(2014). *Оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг судлах арга зүйн зөвлөмж.*Улаанбаатар

Ферн Суссман., (2004) *Үгээр хязгаарлахгүй харилцаа. , Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдүүдийн харилцах, нийгэмших чадварыг хөгжүүлэхэд эцэг эхчүүдэд туслах нь.* Улаанбаатар

Хигашида Наоки., (2015*). Би яагаад үсэрдэг вэ.* Улаанбаатар:

Монголын аутизмын холбоо., (2015). *Аутизмын хүрээний эмгэг. Гиперактив хүүхэд /орос ном/*

Насанцэнгэл,Ё.,(2008) Оюуны хомсдол.Улаанбаатар

Нагата. М, нар (2020) “Монгол Танака Бине” оюун ухааны сорил, Онолын гарын авлага, хх 9, Өнгөт талст ХХК, УБ

М. Нагата нар (2020) “Монгол Танака Бине” оюун ухааны сорил, Оноожуулах гарын авлага, хх 10,5, Өнгөт талст ХХК, УБ

М. Нагата нар (2020) “Монгол Танака Бине” оюун ухааны сорил, Сорил авах гарын авлага, хх 14, Өнгөт талст ХХК, УБ

Одгэрэл. Д (2022) Тэгш хамруулах боловсролын монгол-англи тайлбар толь, Адмон ХХО

Одгэрэл. Д нар (2020) “Сургалтын үйл ажиллагааг дэмжих тусгай хэрэгцээт боловсролын арга зүй, 172 шинэлэг санаа, бага ангийн жишээн дээр, Тошобунзка хэвлэлийн компани

Одгэрэл. Д нар (2022) Сургалтын үйл ажиллагааг дэмжих тусгай хэрэгцээт боловсролын арга зүй, дунд ангийн жишээн дээр, Тошобунка хэвлэлийн компани

Одгэрэл. Д, Оюунтунгалаг. Н, (2020) Зан төрх, танин мэдэхүйн бэрхшээлтэй хүүхдийн талаарх ойлголт, илрүүлэх арга зүй, Бага ангийн багш нарт зориулсан зөвлөмж,УБ

Одгэрэл. Д, Намираа Б. (2018) Тусгай боловсрол, Хөгжлийн онцлогтой хүүхдийг дэмжих онол, арга зүй, Содпресс ХХК, УБ

Хаяаши Кензо., Торигое Такаши., Исава Шинзо., Ишикура Кенжи., Такано Миюүки., (2016). *Тусгай хэрэгцээт боловсрол.* Улаанбаатар:

Хаяаши Кензо. (2007). Тэгш хамруулан сургах боловсрол. УБ

**Мэдээлэл хайх хаяг:**

1) www.meds.gov.mn
2) www.khun.gov.mn
3) www.mons.mn
4) www.mea.orgmn
5) www.savethechildren.org
6) www.forum.mn
7) www.unisef.org
8) www.jica.go.jp
9) www.worldvision.org
10) www.nrc.gov.mn
11) www.autism.mn
12) www.dsam.mn
13) apdc.mongolia@gmail.com
14) www.apdc.mn

**Хичээлийн өмнөх холбоо:**

**Хичээлийн зорилго:** Тэгш хамруулах боловсролын онол зарчимд тулгуурлан боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай бага насны хүүхдийн нас, хувийн онцлог, ялгаатай хэрэгцээнд нийцсэн хүүхэд бүрийг хөгжүүлэх ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулан үйл ажиллагааг зохион байгуулах онол, арга зүйн мэдлэгтэй, улмаар түүнийгээ амьдралд хэрэглэх чадвартай, хүүхэд бүрийг сурч хөгжих тэгш боломжоор хангах эерэг хандлагатай болоход энэхүү хичээлийн зорилго оршино.

**Хичээлийн агуулга:** Тэгш хамруулах боловсролын үзэл санаа, үндсэн ойлголт ухагдахуун, зарчим, түүхэн хөгжил, тэгш хамруулах боловсролын тогтолцооны онцлог ялгаа, хөгжлийн бэрхшээлийн тухай ойлголт, ангилал, нэр томьёо, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга барил, орчин, харилцааны онцлогийг судалж тэдний эцэг эх, гэр бүл, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах арга зүйг эзэмшинэ.

***Хүснэгт 2. Хичээлээр эзэмших мэдлэг, чадвар ба хичээлийн цөм агуулгын хамаарал***

| Хичээлийн цөм агуулга | Хичээлээр эзэмших мэдлэг ур чадварууд |
|---|---|
| Тэгш хамруулах боловсролын үзэл санаа үндсэн ойлголт | CLO: 1.1-1.2 |
| Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдийн хөгжлийн онцлог, ялгаатай хэрэгцээ | CLO: 1.2, 2.2, 3.1, 3.3 |
| Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдийг боловсролд тэгш хамруулах | CLO: 2.1, 3.3, 3.4 |
| Тэгш хамруулах боловсролын хамтын ажиллагаа | CLO: 2.3, 3.2. |

***Хүснэгт 3. Хичээлийн жишиг төлөвлөгөө***

| Лекц | Цаг | Семинар | Цаг |
|---|---|---|---|
| Тэгш хамруулах боловсролын үзэл баримтлал, зарчим үндсэн ухагдахуун | 2 | Тэгш хамруулах боловсролын хууль, эрх зүйн орчин | 2 |
| Тэгш хамруулан сургах боловсролын орчин | 2 | МУ-н тэгш хамруулах боловсролын өнөөгийн байдал, хамруулах боловсролын тулгамдаж буй бэрхшээл | 2 |
| Боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдийн ангилал, тодорхойлолт, | 6 | Зан төлөвийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжин ажиллах нь (түрэмгий зан авиртай) | 2 |
| | | Хэл яриа харилцааны бэрхшээлтэй | 2 |

| | | | |
|---|---|---|---|
| | | хүүхдийн хөгжлийг дэмжин ажиллах нь (АХЭ-тэй хүүхэд, ХЯБ) | |
| | | Анхаарлын дутмагшил хэт хөдөлгөөнтэй хүүхдийн хөгжлийг дэмжин ажиллах нь | 2 |
| Боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдийн хөгжлийн үнэлгээ | 4 | Монгол улс дах тусгай хэрэгцээтэй хүүхдийн үнэлгээ, оношилгоо | 2 |
| | | Оюуны чадварыг үнэлэх “Монгол Танака Бине оюуны ухааны сорил”-н танилцуулга, хэрэглээ | 2 |
| Тусгай хэрэгцээтэй бага насны хүүхдэд боловсрол эзэмшүүлэх зарчим | 4 | Суралцахуйн түгээмэл загвар (UDL) | 2 |
| | | Зан үйлийн шинжилгээний арга (ABA) | 2 |
| Сургалтын хөтөлбөрийн тохиргоо, төлөвлөлт | 6 | Тохируулгат орчин, хэрэглэгдэхүүн | 2 |
| | | Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө (ГСТ) | 2 |
| | | Дэмжлэгийн баг буюу RTI | 2 |
| Эрт үеийн дэмжлэг буюу Интервенц | 4 | Эрт үеийн хөгжлийн дэмжлэг, оролцооны хөтөлбөр | 2 |
| | | Гэр бүл төвт эрт үеийн хөгжлийн дэмжлэг, оролцооны Портеж хөтөлбөр | 2 |
| Тэгш хамруулах боловсролын хамтын ажиллагаа | 4 | Боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй гэр бүлийг дэмжих, хамтран ажиллах | 2 |
| | | Эцэг эх, гэр бүл, олон нийтийн хамтын ажиллагаа<br>Олон нийтийн хамтын ажиллагаа | 2 |

**Хичээлийн арга зүй:** Суралцагч бүрийн бүтээлч байдал, шүүмжлэлт сэтгэлгээ, бие даан суралцах, академик бичлэг хийх, асуудлыг шийдвэрлэх, хамтран ажиллах, харилцан ярилцах, илтгэх чадвараа сайжруулах, мэдээлэл боловсруулах “оюутан төвт” сургалтыг зохион байгуулах тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдийн хөгжлийг дэмжих эерэг хандлага төлөвшүүлнэ.

**Үнэлгээ:** Суралцагчдын идэвх, санаачилга, бүтээлч байдлыг идэвхжүүлэх, дэмжих зорилго бүхий үнэлгээг тэдний бие даалтын ажлын гүйцэтгэл, явцын сорил, ирц, идэвх оролцооны нэгдмэл үзүүлэлтээр шударга, ил тод, нээлттэй бодитой үнэлнэ.

*Хичээлд суусан, оролцсон байдлын үнэлгээ*
Суралцагчдын лекц, семинарын ирц, оролцоог тус бүр 10 хувиар үнэлнэ. Хүндэтгэх шалтгаангүй хичээл тасалсан тохиолдол бүрд авбал зохих хувиас 0.5 түүнээс дээш хувь хасаж тооцно. Хичээлийн үеэр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэтгэлцэх, асуулт асуух, даалгаврыг цаг хугацаанд гүйцэтгэх, илтгэл хэлэлцүүлэх, тоглох, тоглоомын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах зэрэг сургалтын үйл ажиллагаанд тасралтгүй идэвхтэй оролцсон тохиолдолд 5% хувийн үнэлгээ өгнө. Хүндэтгэх шалтгаангүйгээр даалгавар гүйцэтгээгүй тохиолдол бүрд авбал зохих хувиас 0.5-ийг хасаж тооцно.

*Бие даан гүйцэтгэх даалгаврын үнэлгээ*
Бие даан гүйцэтгэх хоёр даалгаврыг тус бүр 50 хувиар үнэлнэ.

<u>Бие даан гүйцэтгэх даалгавар 1.</u> Эргэцүүлсэн эсээ, ганцаарчлан гүйцэтгэнэ.

- Тэгш хамруулан сургах боловсролын талаар эргэцүүлсэн эсээ бичих

<u>Бие даан гүйцэтгэх даалгавар 2.</u> Туршилт судалгаа хийнэ. Ганцаарчлан гүйцэтгэнэ.

- Хөгжлийн хоцрогдолтой болон хөгжлийн бэрхшээлтэй 1 хүүхдэд эрт хөгжлийн дэмжлэг, оролцооны Портеж хөтөлбөрөөр даалгавар боловсруулж хүүхдийн хөгжлийг дэмжин ажиллаж үр дүнг судална.

<u>Бие даан гүйцэтгэх даалгавар 3.</u> Тоглоомын аргачлал боловсруулж, туршилт хийх: Багаар хийж гүйцэтгэнэ.

- Хөгжлийн хоцрогдолтой болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих тоглоомын аргачлал боловсруулж, туршин үр дүнг хэлэлцүүлнэ.

**Явцын үнэлгээ:** Явцын шалгалтыг хоёр удаа авна.

**Явцын шалгалт I.** Хичээлийн эхний 8 удаагийн лекц болон 8 удаагийн семинарын агуулгаар сорил авна. (15 оноо)
**Явцын шалгалт II**. Хичээлийн дараагийн 8 удаагийн лекц болон 8 удаагийн семинарын агуулгаар сорил авна. (20 оноо)

**“ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫН ҮНДЭС” (T.PE203)**
**ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА**

## Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ

### 1. Хичээлээр эзэмших мэдлэг, чадвар, хандлага (CLO):

1.1. Тэгш хамруулах боловсролтой холбоотой эрх зүйн баримт бичгүүдийг нэрлэх, мөн чанарыг орчин үеийн боловсролын үзэл баримтлалтай холбон тайлбарладаг.

1.2. Тэгш хамруулах боловсрол шаардлагатай суралцагчдын хөгжлийн болон суралцахуйн онцлогийг жишээгээр тайлбарладаг, гэр бүл, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх арга замыг тодорхойлж, төлөвлөдөг.

1.3. Тэгш хамруулах боловсролын үндсэн зарчмууд, хэрэгжүүлэх арга замыг үндэслэлтэйгээр тодорхойлдог.

2.1. Тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдүүд, тэдгээрийн онцлог, үйл ажиллагааны алдагдал, өөрчлөлтийг илрүүлдэг.

2.2. Боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн ГСТ төлөвлөж, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлдог, тэгш хамруулан сургах зарчим дээр тулгуурлан СТЗ-аар сургалт зохион байгуулж, үр дүнг хэлэлцүүлдэг.

2.3. ЕБС-ийн ердийн анги дахь ялгаатай хэрэгцээтэй суралцагчдын онцлог, сургалтын түгээмэл загвар, орчин үеийн суралцахуйн онолд үндэслэн сурах сургах арга, анги танхимын зохион байгуулалтын хувилбар боловсруулдаг.

3.1. Суралцагчийн онцлог, ялгаатай хэрэгцээг мэдэх, тодорхойлох, ойлгох, хүндэтгэлтэй хандах, хүүхэд бүр сурч чадна гэдэг итгэл өгөх, тэднийг сургалт хүмүүжлийн зорилго зорилтдоо хүрэхэд нь чин сэтгэлээсээ туслан дэмждэг.

3.2. Сургалтын орчин дахь эрх тэгш оролцоог бүрдүүлж, сурагч бүр бие биеэ хүндэтгэсэн шударга, ёс зүйтэй эерэг харилцааг дэмждэг, сайжруулах арга замыг эрэлхийлдэг, сурагчийн эцэг эх, асран хамгаалагчидтай нягт хамтран ажиллаж тэдэнд хүүхдийнх нь тусгай хэрэгцээ, онцлог байдлыг ухамсарлан ойлгуулж, хүүхдийнхээ чадавхаа бүрэн дайчилж хөгжихөд нь хөтлөх, арга зүйн дэмжлэг үзүүлдэг.

### 2. Үнэлгээний хэлбэр, жин:

*Хүснэгт 1. Үнэлгээний хэлбэр ба багтаамж*

| № | Үнэлгээний хэлбэр | Эзлэх хувь | Багтаамж |
|---|---|---|---|
| 1 | Ирц, оролцоо | 20% | 3. Лекц болон семинарын хичээлийн ирцийг бүртгэж 20%тооцно.<br>4. Семинарын сэдэвтэй холбоотой гүйцэтгэх судалгаа, дасгал даалгаврын гүйцэтгэл, тэмдэглэл хөтөлсөн байдлыг 50%-аар тооцно. |

| | | | |
|---|---|---|---|
| 2 | Бие даах ажил | 50% | 1. Бие даасан бичил судалгаа 50%<br>2. Үндэслэл, нотолгоо бүхий эсээ 50% |
| 3 | Явцын үнэлгээ | 30% | Хоёр удаагийн сорил болон бүтээлч даалгавар сонгон гүйцэтгэж болно. |

**Хоёр. ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

**Хичээлийн нэр, код;** Тэгш хамруулах боловсролын үндэс; T.PE203
**Судлах улирал:** Намар
**Цагийн задаргаа, кредитийн хэмжээ**: 1:2:0:0 (2) (лекц: семинар)
**Заах багш:** Д.Одгэрэл, Ph.D, дэд.профессор odgerel@msue.edu.mn

**Ажлын өрөө:** 5-210
**Ажиллах цаг:** Даваа–Баасан, 9:00 am – 18:00 pm.

**Үндсэн сурах бичиг**:
Д. Одгэрэл, Б. Намираа. (2018).“Тусгай боловсрол” Хөгжлийн онцлог бүхий суралцагчдыг дэмжих онол, арга зүй, Содпресс ХХК, УБ 250 хуудастай, (31,25 х.х), 11 бүлэгтэй.
Д. Одгэрэл, Ч. Нямдорж. (2022). Тэгш хамруулан сургах боловсролын үндэс, 1 дэх хэвлэл, Адмон ХХК
Д.Одгэрэл нар. (2020).”Тэгш хамруулах боловсрол”, ХИС, Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих төсөл
Д.Одгэрэл нар. (2020).“Суралцахуйн үйл ажиллагааг дэмжих тусгай хэрэгцээт боловсролын 172 шинэлэг санаа /бага ангийн жишээн дээр” гарын авлага
Д. Одгэрэл, Н.Оюунтунгалаг. (2020). “Зан төрх, танин мэдэхүйн бэрхшээлтэй хүүхдийн талаарх ойлголт, илрүүлэх арга зам” гарын авлага

**Нэмэлт судлах материал:**
МУИХ. (2016). *Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах хууль.*
МУИХ. (2016). *Хүүхдийн эрхийг хамгаалах хууль.*
БСШУЯ, UNICEF SIDA. (2007). *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт- шинжилгээ.* Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК
ЮНЕСКО. (2015). *Инчоны тунхаглал.*
ДЭМБ. (2001.) Олон улсын үйл ажиллагааны ангилал.
Бэгз, Н. Цэвээнлхаазал, Я. Энхээ, Д. (2009). *Бага Боловсролын сурган хүмүүжүүлэх зүй.* Улаанбаатар:
**ЮНЕСКО. БСШУЯ. (2015). *Тэгш хамруулан сургах багшийн боловсрол.*** Улаанбаатар: **Адмон принт**

Special Needs Education Conference. (1994). Salamanca Declaration: Access and Quality, UNESCO. Spain, Salamanca
Warnock, H.M. (1978). Special Educational Needs, UK Department of Education and Science, London
Боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдүүдтэй ажиллах арга зүй, гарын авлага. (2016). МУБИС, Нагоя Их Сургуулийн төслийн баг, Битпресс ХХК
ЮНЕСКО. Тэгш хамруулан сургах багшийн боловсрол, зөвлөмж. (2015). Адмон принт, ХХК, УБ
UNICEF, IRIM. (2017). Үйл ажиллагааны модуль, гарын авлага. УБ

**Хичээлийн өмнөх холбоо:**

**Хичээлийн тодорхойлолт**: "Тэгш хамруулан сургах боловсролын үндэс" хичээл нь бага ангийн багш мэргэжлээр суралцаж буй оюутны заавал судлах мэргэжлийн хичээлүүдийн нэг юм. Энэ хичээлээр оюутан тэгш хамруулах боловсролын үндэс, тусгай хэрэгцээт сурагчдын оношилгоо, дэмжлэг болон суралцахуйн бэрхшээлтэй сурагчдын талаар судалж, тэдэнд тохирсон ганцаарчилсан сургалт зохион байгуулах баримжаатай болно.
Оюутан бүрийн бүтээлч, шүүмжлэлт сэтгэлгээ, бие даан суралцах, бичил судалгааны багт хамтран ажиллах, асуудлыг шийдвэрлэх, хамтран ажиллах, харилцан ярилцах, мэдээлэл боловсруулахад суралцан өөрийгөө хөгжүүлэхэд чиглэсэн идэвхтэй сургалтыг зохион байгуулна.

**Хичээлийн зорилго:** Тэгш хамруулах боловсрол, түүний орчин үеийн чиг хандлага, үзэл баримтлалд тулгуурлан суралцагчдын хэрэгцээ, онцлогийн харгалзан тэгш хамруулах сургалтыг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах суурь мэдлэг, чадвар эзэмшинэ.

**Хичээлийн агуулга:** Тэгш хамруулах боловсролын үндэс хичээл нь 3 үндсэн агуулгаас бүрдэнэ. Тэгш хамруулах боловсролын үзэл баримтлал, ухагдахууныг ялган таньж, сурагч бүрийн онцлогт нийцүүлэн тэгш хамруулах сургалт, ганцаарчилсан сургалт зохион байгуулах мэдлэг, чадвар эзэмшинэ.

***Хүснэгт 2. Хичээлээр эзэмших мэдлэг, чадвар, хандлага ба хичээлийн цөм агуулгын хамаарал***

| Хичээлийн цөм агуулга | Хичээлийн эзэмших мэдлэг, чадвар |
|---|---|
| Тэгш хамруулах боловсролын үзэл баримтлал, концепц, тулгуур ухагдахуун, тэгш хамруулах боловсролын хамтын ажиллагаа, ГСТ, СТЗ-ыг хослуулан тэгш хамруулах боловсролыг хэрэгжүүлэх арга замын талаарх мэдлэг | CLO 1.1-1.3 |
| Тэгш хамруулах боловсролын ухагдахууны агуулгыг онол-практикийн үүднээс тайлбарлаж, дүн шинжилгээ хийх | CLO 2.1-2.3 |

| | |
|---|---|
| ГСТ, СТЗ-ыг хичээл, сургалтын явцад хэрэглэх чадвар | |
| ТэХБ-ын хичээлээр хүүхэд бүрийн онцлог, тусгай хэрэгцээг хангах тэдний хэрэгцээнд нийцсэн сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэх, хүүхэд бүр сурч чадна гэсэн итгэл үнэмшилтэй байх | CLO 3.1-3.2 |

*Хүснэгт 3. Хичээлийн жишиг төлөвлөгөө*

| Долоо хоног | Лекц | Семинар | Лекц цаг | Сем цаг |
|---|---|---|---|---|
| **ТэХБ-ийн талаарх ойлголт, эрх зүйн баримт бичгүүд, Тэгш хамруулан сургах боловсролын үзэл баримтлал, судлах, харьцуулах** | | | | |
| 1 | Удиртгал | ТХБ-ын тулгуур ухагдахуун, үзэл баримтлал | 2 | 2 |
| | | ТХБ-ын түүхэн хөгжил, орчин үеийн чиг хандлага | | 2 |
| 2 | ТХБ-ын эрх зүйн орчин, нэр томьёо, үг хэллэг | Монгол дахь эрх зүйн орчин | 2 | 2 |
| | | Нэр томьёо, үг хэллэг | | 2 |
| **Хүүхэд бүрийн ялгаатай байдал, суралцахуйд нөлөөлөх хүчин зүйлс, (Суралцахуйн түгээмэл загвар)** | | | | |
| 3 | Суралцахуйн түгээмэл загвар | Суралцахуйд нөлөөлөх хүчин зүйлс | 2 | 2 |
| | | Суралцахуйн түгээмэл загвар | | 2 |
| 4 | Мэдээлэл харилцааны технологи | СТЗ ба МХТ | 2 | 2 |
| | | Явцын үнэлгээ | | 2 |
| **Тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн онцлог, дэмжих арга зам (ГСТ)** | | | | |
| 5 | Тусгай хэрэгцээтэй хүүхдийн хөгжлийн үнэлгээ, оношилгоо | Оюун ухаан, хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүүхдүүдийн онцлог, үнэлгээ | 2 | 2 |
| | | Бие эрхтний бэрхшээлтэй эрхтний хүүхдүүдийн онцлог, үнэлгээ | | 2 |
| 6 | Тусгай хэрэгцээтэй хүүхдийн дэмжлэг үзүүлэх арга зүй, ГСТ | Оюун ухааны бэрхшээлтэй хүүхдүүдийг дэмжих арга зам | 2 | 2 |
| | | Харааны, сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийг дэмжих арга зам | | 2 |
| **Зан төрх, танин мэдэхүйн бэрхшээлтэй суралцагчид, тэдгээрийг илрүүлэх, үнэлэх, дэмжих арга зам** | | | | |
| 7 | Зан төрх танин мэдэхүйн бэрхшээлтэй хүүхдийн үнэлгээ | Дэмжих арга зам | 2 | 2 |
| | | Дэмжих арга зам | | 2 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 8 | Суралцахуйн бэрхшээлтэй хүүхдүүдийн онцлог, үнэлгээ | Дэмжих арга зам | 2 | 2 |
| | | Дэмжих арга зам | | 2 |
| | | Нийт /цаг/ | 16 | 32 |

**Хичээлийн арга зүй:** Хичээлийг оюутны оролцоо төвтэй, бүтээлч үйл ажиллагааг сэдэлжүүлсэн, эрэл хайгуул, эргэцүүлэл хийх боломжийг бүрдүүлсэн сургалтын сэтгэл зүйн таатай орчныг бүрдүүлэн ажиллахад анхаарна. Сургалтад аудио, видео хэрэглэгдэхүүн, сурагчид ярилцлага, мэтгэлцээн хийх зэрэг интерактив сургалтын арга зүйд тулгуурлана.

Хичээлийн үнэлгээ: хичээлд явцын болон эцсийн үнэлгээг хэрэглэх бөгөөд эцсийн үнэлгээ нь ирц, бие даалт, явц гэсэн бүрэлдэхүүн хэсэгтэй. Бие даалтын шалгуурыг 4-р хүснэгтэд харууллаа.

*Хүснэгт 4. ТэХБ-ийн талаарх ойлголт, онолын үндэс сэдвээр гүйцэтгэх бие даах ажлын сэдэв шалгуур*

| № | Бие даан хийх ажлын сэдэв | Шалгуур |
|---|---|---|
| 1 | Тэгш хамруулах боловсролын эрх зүйн баримт бичигт, эрх зүйн орчныг бүрдүүлж буй арга туршлага, өнөөгийн байдалд хийсэн судалгаа | 1. Мэдээллийн найдвартай эх сурвалж ашиглана (5-10).<br>2. Тухайн сэдвийн хүрээнд өөрийн үзэл бодол, анализ, харьцуулалт хийж бичнэ.<br>3. Оновчтой санал, дүгнэлт, асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхой боловсруулж гаргана.<br>4. Ашигласан эх материалын жагсаалтыг “APA” загварын дагуу хийнэ. Эшлэл зүүлтийг зөв хийнэ..<br>Үг үсэг, хэл найруулгын алдаагүй бичнэ.<br>5.Товлосон хугацаанд хийж гүйцэтгэнэ |
| 2 | Суралцахуйн түгээмэл загварын онол, үзэл баримтлал, практик хэрэгжилт | |
| 3 | ЕБС-ийн багш нар хичээлд сурагчдын тэгш хамруулах орчин нөхцөлийг хангаж байгаа арга туршлагад хийсэн шинжилгээ, санал дүгнэлт | |
| 4 | ЕБС-ийн сургалтад хүүхэд бүрийн онцлог ялгаатай байдлыг харгалзан хэрэгжүүлж байгаа байдалд хийсэн шинжилгээ, санал дүгнэлт | |
| 5 | ЕБС-ийн багш нар ангийн сурагчдынхаа хөгжлийн онлогийг бодитой үнэлж байгаа арга туршлагад хийж буй туршлага, боломж | |

| | | |
|---|---|---|
| 6 | ЕБС-ийн сургалтад тэгш хамруулах бодлого хэр амжилттай хэрэгжиж байгаад хийсэн шинжилгээ, | |
| 7 | ЕБС-ийн сургалтад “Тэгш хамруулан сургах боловсрол”-ын СТЗ-ын хэрэгжилтэд хийсэн шинжилгээ | |
| 8 | ЕБС-ийн багш нар ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллаж буй туршлага /СТЗ/ | |

**“ОРЧИН ҮЕИЙН БАГА БОЛОВСРОЛЫН ХӨГЖИЛ” (T.ED603)**
**ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА**

## Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ

**Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага (CLO):**

1.1. Бага боловсролын хөгжлийн чиг хандлага, орчин үеийн боловсролын онол, үзэл баримтлал (насан туршийн боловсрол, тогтвортой хөгжлийн боловсрол, уур амьсгалын өөрчлөлтийн боловсрол, дижитал боловсрол), түүний хөгжил, чиг хандлагыг тайлбарладаг, харьцуулдаг.
1.2. Тэгш хамруулах боловсролын асуудал, хөгжлийн чиг хандлага, эрх зүйн орчин, тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай суралцагчдын онцлог, сургалтын хөтөлбөр, дэмжлэг үзүүлэх стратегийн талаар судалдаг, нэгтгэн дүгнэдэг.

2.1. Орчин үеийн боловсролын шинэ үзэл баримтлалыг бага боловсролын хөгжилтэй холбон тайлбарлаж, түүнийг судалгаа, шинжилгээний ажилдаа бүтээлчээр тусгадаг.
2.2. Тэгш хамруулах боловсрол, түүний эрх зүйн орчны талаарх мэдлэгээ ашиглаж, хүүхэд, залуучуудын сайн сайхны төлөө төсөл, хөтөлбөр боловсруулдаг.
2.3. Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай суралцагчдыг оношилж, хүүхэд нэг бүрийн онцлогт нийцсэн ГСТ боловсруулж, дэмжлэг үзүүлэх стратегийг хэрэгжүүлдэг.

3.1. Судалгааны ажил хийхдээ орчин үеийн боловсролын онол, үзэл баримтлалын талаарх баталгаа, нотолгоотой эх сурвалж, судалгааг ашигладаг.
3.2. Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай сурагчдын эрхийг хамгаалахад тууштай байгаагаа харуулдаг.
3.3. Бага боловсролын түвшинд тусгай хэрэгцээт боловсролын судалгаа, арга зүйг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулахыг эрмэлздэг.

### 2. Үнэлгээний хэлбэр, жин , багтаамж

*Хүснэгт 1. Үнэлгээний хэлбэр ба багтаамж*

| № | Үнэлгээний хэлбэр | Эзлэх хувь | Багтаамж |
|---|---|---|---|
| 1 | Ирц, оролцоо | 20% | 5. Лекц болон семинарын хичээлийн ирцийг бүртгэж 20%тооцно.<br>6. Семинарын сэдэвтэй холбоотой гүйцэтгэх судалгаа, дасгал даалгаврын гүйцэтгэл, тэмдэглэл хөтөлсөн байдлыг 50%-аар тооцно. |
| 2 | Бие даах ажил | 50% | 3. Бие даасан бичил судалгаа 50%<br>4. Үндэслэл, нотолгоо бүхий эсээ 50% |
| 3 | Явцын үнэлгээ | 30% | Хоёр удаагийн сорил болон бүтээлч даалгавар сонгон гүйцэтгэж болно. |

**Хоёр. ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

| | |
|---|---|
| **Хичээлийн нэр, код:** | “Орчин үеийн бага боловсролын хөгжил” (T.ED603) |
| **Улирал:** | Хавар |
| **Хичээлийн задаргаа**: | 1:2:0:0 (3) (лекц: семинар) |
| **Заах багш:** | Д.Одгэрэл, Д.Ганболд |
| **Мэйл хаяг:** | *odgerel@msue.edu.mn* |
| **Ажлын өрөө:** | 5-210 |
| **Ажиллах цаг:** | Даваа–Баасан, 9:00 am – 18:00 pm. |

**Үндсэн сурах бичиг**:
Д. Одгэрэл, Б. Намираа (2018).“Тусгай боловсрол” Хөгжлийн онцлог бүхий суралцагчдыг дэмжих онол, арга зүй, Содпресс ХХК, УБ.250 хуудастай, (31,25 х.х), 11 бүлэгтэй.
Д.Одгэрэл, Ч. Нямдорж. (2022). ”Тэгш хамруулах боловсролын үндэс”

**Нэмэлт судлах материал:**

MELINC Deliverables – Education and Law Alliances (edulaweu.eu)
МУИХ. (2016). *Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах хууль*.
МУИХ. (2016). *Хүүхдийн эрхийг хамгаалах хууль*
ЮНЕСКО. (2015). *Инчоны тунхаглал*.
ДЭМБ. (2001). Олон улсын үйл ажиллагааны ангилал.
**ЮНЕСКО, БСШУЯ. (2015).** ***Тэгш хамруулан сургах багшийн боловсрол.*** Улаанбаатар: **Адмон принт**
Special Needs Education Conference. (1994). Salamanca Declaration: Access and Quality, UNESCO. Spain, Salamanca
Warnock, H.M. (1978). Special Educational Needs, UK Department of Education and Science, London

**Хичээлийн өмнөх холбоо:** T.PE 203

**Хичээлийн товч тодорхойлолт:** Бага боловсролын хөгжлийн чиг хандлага, орчин үеийн боловсролын онол, үзэл баримтлал (насан туршийн боловсрол, тогтвортой хөгжлийн боловсрол, уур амьсгалын өөрчлөлтийн боловсрол, дижитал боловсрол), тэгш хамрах боловсролын шинжлэх ухааны тулгуур ухагдахуун, концепци, эрх зүй, боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн ангилал, хөгжлийн үнэлгээ, ганцаарчилсан сургалтын төлөвлөлт, тусгай болон тэгш хамруулах боловсролын арга зүй, орчны хүртээмж чанарын асуудлуудыг бага ангийн багш мэргэжлийн онцлог, түүнд тавигдах шаардлага зэрэгт нийцүүлэн судална.

**Хичээлийн зорилго:** Магистрант нь орчин үеийн боловсролын онол, үзэл баримтлал, тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдийн ангилал, онцлог, боловсролын үнэлгээ, үйлчилгээний хамрах хүрээ, тэгш хамруулан сургах ажлын онол, арга зүйг онол-

практикийн үүднээс тайлбарлаж төлөвлөж хүүхэд бүрийн хөгжих нөхцөл боломжоор хангах эрмэлзэл, хандлага мэргэжлийн чиг баримжаатай болоход чиглэж байна.

**Хичээлийн агуулга:** Орчин үеийн боловсролын онол, үзэл баримтлал, тэгш хамруулах боловсролын түүхэн хөгжил, орчин үеийн чиг хандлага, эрх зүйн орчин, зохион байгуулалт, ТэХБ-ын байгууллага, мэргэжилтнүүд, тэдгээрийн үйл ажиллагаа, Боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн боловсролын үнэлгээ, хүүхэд бүрийг дэмжих, хөгжүүлэх арга зүй, ТХБ-ын үйлчилгээ, зохион байгуулалт.

*Хүснэгт 2. Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар ба хичээлийн агуулгын хамаарал*

| Хичээлийн цөм агуулга | Хичээлийн эзэмших мэдлэг, чадвар |
|---|---|
| Бага боловсролын хөгжлийн чиг хандлага , орчин үеийн боловсролын онол, үзэл баримтлал (насан туршийн боловсрол, тогтвортой хөгжлийн боловсрол, уур амьсгалын өөрчлөлтийн боловсрол, дижитал боловсрол), тэгш хамруулах боловсролын концепци, үнэт зүйлс, олон улсын тунхаглал, эрх зүйн дүрэм, журмын болоод хуулийн хэрэгжилт | CLO 1.1-1.5 |
| Боловсролд тэгш хамрагдаж чадахгүй байгаа хүүхдүүдийг хэрэгцээ, хөгжлийн үнэлгээ, дэмжих арга зам; олон нийтийн оролцоо | CLO 2.1-2.4 |
| Хүүхэд бүрийн онцлог, тусгай хэрэгцээг хангах тэдний хэрэгцээнд нийцсэн сургалтын таатай орчин бүрдүүлж сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах, сэтгэл, итгэл үнэмшилтэй байх | CLO 3.1-3.4 |

*Хүснэгт 3. Хичээлийн жишиг төлөвлөгөө*

| **Долоо хоног** | **Цөм агуулга** | **Лекц** | | **Семинар** | |
|---|---|---|---|---|---|
| | | **Сэдэв** | **Цаг** | **Сэдэв** | **Цаг** |
| I | Бага боловсрол | Бага боловролын хөгжлийн чиг хандлага | 2 | Бага боловсролын хөгжлийн тойм | 2 |
| II | | | | Бага боловсролын хөгжлийн чиг хандлага | 2 |
| III | Насан туршийн боловсрол | Насан туршийн боловсролын | 2 | Нийгмийн өөрчлөлт ба XXI зууны боловсрол | 2 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| IV | | асуудал, хөгжлийн чиг хандлага | | Насан туршийн суралцахуй | 2 |
| V | | | | Насан туршийн боловсрол ба суралцахуйн олон хэлбэр | 2 |
| VI | Тогтвортой хөгжлийн боловсрол | Тогтвортой хөгжлийн боловсролын асуудал, хөгжлийн чиг хандлага | 2 | Сургуулийн сургалтын хөтөлбөрт тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг тусгах нь | 2 |
| VII | | Уур амьсгалын өөрчлөлтийн боловсролын асуудал, хөгжлийн чиг хандлага | | Уур амьсгалын өөрчлөлтийн боловсролоор дамжуулж сурагчдын зан төлөвийг өөрчлөх боломж | 2 |
| VIII | Дижитал боловрол | Дижитал боловсролын асуудал, хөгжлийн чиг хандлага | 2 | Дижитал боловсролын сорилтууд, чиг хандлага, үр дагавар | 2 |
| IX | | | | Суралцагч ба багш нарын дижитал чадамж | 2 |
| X | Компетенци буюу цогц чадамж | XXI зууны компетенци | 2 | Суралцахуй, шинэчлэхүйн цогц чадамж | 2 |
| XI | | | | Санаачилга, ажил хэргийн цогц чадамж | 2 |
| XII | Тэгш хамруулах боловсрол | Тэгш хамруулах боловсролын асуудал, хөгжлийн чиг хандлага | 2 | Хүүхэд бүрийн суралцах хувийн онцлог, суралцахуйд нөлөөлөх хүчин зүйлс | 2 |
| XIII | | Тэгш хамруулан сургах боловсролын | 2 | Эрх зүйн орчин хүүхэд нэг бүрийн ялгаатай байдал, суралцахуйд нөлөөлөх нь | 2 |
| XIV | | | | Олон улсын хүний эрхийн | 2 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | эрх зүйн орчин | | тухай хууль тогтоомжид тэгш хамруулах боловсролыг тусгасан байдал | |
| XV | | Тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн онцлог, дэмжих арга зам | 2 | Тусгай хэрэгцээтэй хүүхдийн хөгжлийн үнэлгээ | 2 |
| XVI | | | | Оюун ухаан, хараа, сонсгол, хэл яриа, тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүхдүүдийн онцлог, тэдний суралцахуйг дэмжих арга зам | 2 |
| Бүгд | | | 16 | | 32 |

**Хичээлийн арга зүй:** Хичээлийг оюутны оролцоо төвтэй, бүтээлч үйл ажиллагааг сэдэлжүүлсэн, эрэл хайгуул, эргэцүүлэл хийх боломжийг бүрдүүлсэн сургалтын сэтгэл зүйн таатай орчныг бүрдүүлэн ажиллахад анхаарна. Сургалтад аудио видео хэрэглэгдэхүүн, сурагчид ярилцлага мэтгэлцээн хийх зэрэг интерактив сургалтын арга зүйд тулгуурлана.

**Үнэлгээ:** Бие даалт болон явцын үнэлгээгээр цуглуулсан мэдээлэл дээр тулгуурлан, эцсийн үнэлгээг хийнэ. Эцсийн үнэлгээ нь ирц, бие даалт, явц гэсэн бүрэлдэхүүн хэсэгтэй байна.

**“ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛ” (E.IE302)**
**ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА**

**Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ**

**3. Хичээлээр эзэмших мэдлэг, чадвар, хандлага (CLO):**

1.1. Тэгш хамруулах боловсролын үзэл баримтлал, зарчим, үндсэн ухагдахууныг ялган таньж, тэдгээрийг зүй зохистой хэрэглэдэг.

1.2. Тэгш хамруулах боловсролын талаарх эрх зүйн баримт бичгийн жагсаалт гаргаж, тэдгээрийг тодорхой аргачлалын дагуу шинжилдэг.

2.1. Суралцагч бүрийн хэрэгцээ, онцлогийг оношлон шинжилж, түүнд нийцүүлэн суралцахуйн түгээмэл загварыг хэрэгжүүлэх тодорхой арга, аргачлалыг дэвшүүлдэг.

2.2. Суралцагч бүрийн хэрэгцээ, онцлогт нийцүүлэн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг өгсөн алхмын дагуу боловсруулж, суралцахуйн уян хатан, таатай орчинг бүрдүүлэхийн тулд анги танхимын менежентийг төлөвлөдөг.

3.1. Суралцагчийн онцлог, ялгаатай байдалд хүндэтгэлтэй ханддаг, тэдний эрхийг дээдлэн ойлгож харьцах хүсэл эрмэлзэлтэй.

3.2. Суралцагч бүрийн хэрэгцээ, онцлогтой холбоотойгоор үүсэх асуудлыг олж харах, түүнийг шийдвэрлэхийн тулд хамтран ажиллаж, олон нийтийн оролцоог хангадаг, шаардлагатай үед бусдаас дэмжлэг авахад бэлэн байдаг.

**4. Үнэлгээний хэлбэр, жин:**

*Хүснэгт 1. Үнэлгээний хэлбэр ба багтаамж*

| № | Үнэлгээний хэлбэр | Эзлэх хувь | Багтаамж |
|---|---|---|---|
| 1 | Ирц, оролцоо | 20% | Ирц: 10 % Лекц семинарын хичээлд ирсэн байдал<br>Оролцоо: 10 % Семинарын тэмдэглэл, багийн ажлын оролцоо, хэлэлцүүлэг удирдсан, асуултад хариулсан байдал зэргийг харгалзан үнэлнэ. |
| 2 | Бие даах ажил | 50% | №1. Тэгш хамруулан суралцагчдын хэрэгцээ, онцлогийг судлах, шинжлэх<br>№2. Тэдний онцлогт тохирсон үйл ажиллагаа төлөвлөх, хэрэгжүүлэх<br>№ 3. Тэгш хамруулах боловсролын чиглэлээр өөрийн хэрэгжүүлсэн үйл ажиллагааг үнэлэх, сайжруулах чиглэл тогтоох |

| | | | |
|---|---|---|---|
| 3 | Явцын үнэлгээ | 30% | Хичээлийн агуулгын дагуу оюутны эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагад гарсан өөрчлөлтийг үнэлнэ.<br>*Өдөр тутмын явцын үнэлгээнд:* Метафор, гарах хуудас, өөрийн үнэлгээний хянах хуудас зэрэг аргачлалыг хэрэглэж, лекц, семинар дахь оюутны идэвх, оролцоог үнэлнэ.<br>*Явцын үр дүнгийн үнэлгээнд:* Сорил, тохиолдлын шинжилгээ, хэлэлцүүлэг, ярилцлага зэрэг аргыг хэрэглэн, хичээлээр эзэмших мэдлэг, чадвар, хандлагын өөрчлөлтийг үнэлнэ. |

**Хоёр. ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

| | |
|---|---|
| **Хичээлийн нэр, код:** | ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛ, E.IE302 |
| **Улирал**: | Хавар |
| **Кредит:** | 3 |
| **Хичээлийн задаргаа**: | 2:2:0:0 (5) |
| **Заах багш:** | БСАЗ-н тэнхмийн багш нар |
| **Е-мэйл хаяг:** | bayarmaa.g@msue.edu.mn |
| **Утас:** | (976)-70120014 |
| **Ажлын өрөө:** | МУБИС-ийн хичээлийн 9-р байр, №502 |
| **Ажиллах цаг:** | Даваа – Баасан, 9:00 AM – 18.00 PM |
| **ULMS хаяг:** | http://203.212.28.101/index.aspx |

**Үндсэн сурах бичиг:**

Одгэрэл,Д. ба нар (2022). "*Тэгш хамруулан сургах боловсролын үндэс*". Улаанбаатар. Адмон Принт ХХК

**Нэмэлт унших материал**:

Дэлгэрмаа,Д. (2020). *Хувийн ялгааг илрүүлэх судалгааны аргууд*. Улаанбаатар. Үсэг хоршоо ХХК

Батцэнгэл,Г. (2018). *Тусгай хэрэгцээт боловсрол*. Улаанбаатар. Соёмбо Принтинг ХХК

Одгэрэл,Д. (2022). "*Тэгш хамруулах боловсролын нэр томьёоны Монгол-Англи тайлбар толь*". Улаанбаатар. Адмон Принт ХХК

Жадамба, Б ба нар. (2022). *Суралцагчдын ялгаатай байдлыг харгалзсан ах сургалт*". Улаанбаатар. Соёмбо Принтинг ХХК

Хаяши Кензо. (2007). "*Тэгш хамруулан сургах боловсрол*" Улаанбаатар.

БШУЯ-ын сайдын тушаал. (2003). "*Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах хөтөлбөр*" 435/302/173 тоот тушаал. Улаанбаатар.

ЗТБХБ-ын сайдын тушаал. (2011). "*Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орон зай, орчны зураг төсөл зохиох дүрэм*" 256-р тушаалын 6-р хавсралт. Улаанбаатар.

МУ-ын стандарт. (2009). "*MNS 6056:2009 Явган хүн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар*". Улаанбаатар.

МУЗГ-ын тогтоол. (2006). "*Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үндэсний хөтөлбөр*" 283-р тушаал

УИХ. Монгол улсын хууль. "*Боловсролын тухай"*. (2002). Улаанбаатар.

УИХ. Монгол улсын хууль. "*Бага, дунд боловсролын тухай хууль"*. (2007). Улаанбаатар.

УИХ. Монгол улсын хууль. "*Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль*". (2016). Улаанбаатар.

**Хичээлийн өмнөх холбоо:**
(E.ES 201)

**Хичээлийн тодорхойлолт**:
"Тэгш хамруулан сургах боловсрол" хичээл нь боловсрол судлаач–аргазүйч мэргэжлээр суралцаж буй оюутны заавал судлах мэргэжлийн хичээлүүдийн нэг юм.

Энэ хичээлээр оюутан тэгш хамруулах боловсрол, олон улсын үзэл хандлага, зарчим, орчин үеийн чиг хандлага зэрэгт тулгуурлан суралцагчийн хэрэгцээ, онцлог, сургууль, ангийн зохион байгуулалт, орчин, үйлчилгээний хэлбэр, бүтэц, зохион байгуулалт, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалтыг зохион байгуулах баримжаатай болно.

Оюутан бүрийн бүтээлч, шүүмжлэлт сэтгэлгээ, бие даан суралцах, бичил судалгааны багт хамтран ажиллах, асуудлыг шийдвэрлэх, хамтран ажиллах, харилцан ярилцах, мэдээлэл боловсруулахад суралцан өөрийгөө хөгжүүлэхэд чиглэсэн идэвхтэй сургалтыг зохион байгуулна.

**Хичээлийн зорилго:**
Тэгш хамруулах боловсрол, олон улсын болон монголын үзэл хандлага, зарчим, орчин үеийн чиг хандлага зэрэгт тулгуурлан суралцагчдын хэрэгцээ, онцлогийн харгалзан тэгш хамруулах сургалт, орчин нөхцөлийг шинжлэх ухааны үндэстэй хангах суурь мэдлэг, чадвар эзэмших

**Агуулга:**
Тэгш хамруулах боловсрол, олон улсын үзэл хандлага, зарчим, тэгш хамруулах сургууль, ангийн зохион байгуулалт, орчин, үйлчилгээний хэлбэр, бүтэц, зохион байгуулалт, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалтыг зохион байгуулах арга зам гэсэн агуулгыг судална.

***Хүснэгт 2. Хичээлээр эзэмших мэдлэг, чадвар, хандлага ба хичээлийн цөм агуулгын хамаарал***

| **Хичээлийн цөм агуулга** | **Хичээлээр эзэмших мэдлэг, чадвар, хандлага** |
|---|---|
| Тэгш хамруулах боловсролын үзэл баримтлал | CLO: 1.1, 1.2; 3.1 |
| Тэгш хамруулах боловсролыг хэрэгжүүлэх арга зам | CLO: 2.1; 2.2; 3.2 |
| Тэгш хамруулах боловсрол ба хэрэгжилт | CLO: 2.2, 3.1, 3.2 |

***Хүснэгт 3. Хичээлийн жишиг төлөвлөгөө***

| **До** | | **Лекц** | **Семинар** |
|---|---|---|---|

| | Цөм агуулга | Сэдэв | Цаг | Сэдэв | Цаг |
|---|---|---|---|---|---|
| I | Тэгш хамруулах боловсролын үзэл баримтлал | Удиртгал лекц | 2 | Удиртгал семинар | 2 |
| | | Тэгш хамруулах боловсролын мөн чанар, орчин үеийн чиг хандлага | 2 | Тэгш хамруулах боловсролын талаарх видеобичлэг үзэх, үзэл бодлоо илэрхийлэх | 2 |
| II | | Тэгш хамруулах боловсролын үндсэн ойлголт, ухагдахуун | 4 | Үндсэн ухагдахуунуудыг тодорхойлон хэлэлцэж, утгыг тайлбарлах | 2 |
| III | | Тэгш хамруулах боловсролын эрх зүйн орчин | 2 | Тэгш хамруулах боловсролын эрх зүйн баримт бичгийг шинжлэх | 2 |
| IV | | Тэгш хамруулах боловсролын олон улсын туршлага | 2 | Тэгш хамруулах боловсролоор олон улсын туршлагыг шинжлэх, давуу ба сул талыг илрүүлэх | 2 |
| V | | | | Монгол дахь тэгш хамруулах боловсролын өнөөгийн нөхцөл байдлыг шинжлэх | 2 |
| VI | Тэгш хамруулах боловсролыг хэрэгжүүлэх арга зам | Тэгш хамруулах боловсролын зарчим | 2 | Үл тоох, тусгаарлах, интеграцчилах, тэгш хамруулан сургахын ижил ба ялгаатай талыг илрүүлэх | 2 |
| VII | | Тэгш хармуулан суралцагчид, онцлог | 4 | Тэгш хамруулан суралцагчдын хэрэгцээ, онцлогийг судлах нь | 2 |
| VIII | | | | Суралцахуйн бэрхшээлтэй, анхаарлын дутмагшилтай, хэт хөдөлгөөнтөх эмгэгтэй суралцагчидтай ажиллах нь | 4 |
| X | | Суралцахуйн түгээмэл загвар | 4 | Суралцахуйн түгээмэл загварын мөн чанарыг тайлбарлах, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох | 2 |
| XI | | | | Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах, | 2 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | тохиргоо хийх | |
| XII | | | | Олон нийт, хамтын үйл ажиллагааг төлөвлөх нь | 2 |
| XIII | | Суралцахуйн тохиргоот орчин | 2 | Суралцагчдын онцлогт нийцүүлэн сургалтын орчиныг бүрдүүлэх | 2 |
| XIV | | Тэгш хамруулах боловсрол – техник технологийн дэвшил | 4 | Тэгш хамруулах боловсролыг хэрэгжүүлэхэд орчин үеийн техник технологийн дэвшлийн хэрэглэх нь | 2 |
| XV<br>XVI | Тэгш хамруулах боловсрол ба хэрэгжилт | Тэгш хамруулах боловсролын үр дүн, үнэлгээ | 4 | Тэгш хамруулах боловсролын үр дүнг бодит байдалд ажиглах | 2 |
| | | **БҮГД:** | **32** | **БҮГД:** | **32** |

**Аргазүй:**
Оюутан бүрийн бүтээлч, шүүмжлэлт сэтгэлгээ, бие даан суралцах, бичил судалгааны багт хамтран ажиллах, асуудлыг шийдвэрлэх, хамтран ажиллах, харилцан ярилцах, мэдээлэл боловсруулахад суралцан өөрийгөө хөгжүүлэхэд чиглэсэн идэвхтэй сургалтыг зохион байгуулна.

**Үнэлгээ:**
Оюутны эзэмших мэдлэг, чадвар, хандлагыг улирлын явцад болон төгсгөлд үнэлнэ. Явцын үнэлгээний гол хэлбэр нь оюутны өөрийн үнэлгээ, багшийн үнэлгээ байх ба мэдлэг, чадварын ахицыг сорилоор үнэлнэ.

**Хичээлд сууж, оролцсон байдлын үнэлгээ:**
Лекц семинарын хичээлд бэлтгэлтэй ирж оролцсон байдлыг гол шалгуур болгон үнэлнэ. Семинарын хичээлийн бэлтгэл, хичээлийн тэмдэглэл болон хичээлийн турших оролцоо, нэмэлт онооны даалгаврын гүйцэтгэл, багийн ажилд оруулж буй хувь нэмрийг харгалзана.

***Хүснэгт 4. Хичээлийн оролцоог үнэлэх шалгуур***

| № | Лекц, семинарын хичээлд оролцсон байдал | Эзлэх % | Багтаамж |
|---|---|---|---|
| **1** | Семинарт бэлтгэж ирсэн байдал | 30 % | 3 оноо |
| **2** | Семинарын явцад хэлэлцүүлэгт оролцож, үзэл бодлоо | 20 % | 2 оноо |

| | | | |
|---|---|---|---|
| | илэрхийлж, санал зөвлөгөө өгсөн байдал | | |
| **3** | Семинарын үр дүнг үнэлсэн байдал | 20 % | 2 оноо |
| **4** | Семинарын үр дүнд өөрийн гүйцэтгэлийг сайжруулсан байдал | 30 % | 3 оноо |
| | **Нийт** | **100 %** | **10 оноо** |

**Бие даах ажлын сэдвүүд:** Бие даах ажлуудыг дараах сэдвүүдээс сонгон авч гүйцэтгэнэ. Үүнд:

№1. Тэгш хамруулан суралцагчдын хэрэгцээ, онцлогийг судлах, шинжлэх
- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг оношлох
- Оюуны бэрхшээлтэй суралцагчдыг оношлох
- Суралцахуйн бэрхшээлтэй суралцагчдыг оношлох
- Аутизмтай суралцагчдыг оношлох
- Анхаарлын дутмагшилтай, хэт хөдөлгөөнтөх эмгэгтэй суралцагчдыг оношлох г.м

№2. Тэдний онцлогт тохирсон үйл ажиллагаа төлөвлөх, хэрэгжүүлэх
- Суралцагчдын хэрэгцээ, онцлогт нийцүүлэн хичээл төлөвлөх, хэрэгжүүлэх
- Суралцагчдын хэрэгцээ, онцлогт нийцүүлэн хичээлээс гадуурх үйл ажиллагаа төлөвлөх, хэрэгжүүлэх
- Суралцагчдын хэрэгцээ, онцлогт нийцүүлэн эцэг эхтэй хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх
- Суралцагчдын хэрэгцээ, онцлогт нийцүүлэн тохиргоот орчныг бүрдүүлэх ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэх г.м
-

№ 3. Тэгш хамруулах боловсролын чиглэлээр өөрийн хэрэгжүүлсэн үйл ажиллагааг үнэлэх, сайжруулах чиглэл тогтоох

***Хүснэгт 5. Бие даах ажлын хэлбэр ба үнэлэх шалгуур***

| Ажлын хэлбэр | Үнэлэх шалгуур |
|---|---|
| Бие даалт №1. Тэгш хамруулан суралцагчдын хэрэгцээ, онцлогийг судлах, шинжлэх | - Сэдвийг сонгосон үндэслэл<br>- Суралцагчдын оношлох арга зүйгээ сонгосон байдал<br>- Оношилгооны арга зүйн боловсруулалт<br>- Мэдээлэл цуглуулсан байдал<br>- Мэдээллийг боловсруулалт<br>- Дүгнэлт, зөвлөмж гаргасан байдал |
| Бие даалт №2. Тэдний онцлогт тохирсон үйл ажиллагаа төлөвлөх, хэрэгжүүлэх | - Үйл ажиллагааг сонгосон үндэслэл<br>- Төлөвлөлт<br>- Төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байдал |
| Бие даалт №3. Тэгш хамруулах боловсролын чиглэлээр өөрийн | - Өөрийн зохион байгуулсан үйл ажиллагааг үнэлэх шалгуур боловсруулсан байдал<br>- Үйл ажиллагаанд өөрийн үнэлгээ хийсэн байдал |

| | |
|---|---|
| хэрэгжүүлсэн үйл ажиллагааг үнэлэх, сайжруулах чиглэл тогтоох | - Цаашид сайжруулах чиглэлийг оновчтой тогтоосон байдал |

**Мэдлэг, чадвар эзэмшилтийн явц ба ахицыг үнэлэх арга, хэлбэр:**
Хичээлээр хүрэх үр дүнгийн хэрэгжилтийг хоёр удаагийн сорилоор үнэлнэ. Сорил нь Блум Таксономийн I-VI танин мэдэхүйн түвшний 10 даалгавраас бүрдэнэ. Сорил нь олон хувилбартай байна.

***Хүснэгт 6. Даалгаврын блюпринт***

| **Хүрэх үр дүн** | **Таксономийн түвшин** | | | | | | ***Нийт*** |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **I** | **II** | **III** | **IV** | **V** | **VI** | |
| Тэгш хамруулах боловсролын үзэл баримтлал, зарчим, үндсэн ухагдахууныг ялган таньж, тэдгээрийг зүй зохистой хэрэглэдэг | 1 | 1 | | | | | 2 |
| Тэгш хамруулах боловсролын талаарх эрх зүйн баримт бичгийн жагсаалт гаргаж, тэдгээрийг тодорхой аргачлалын дагуу шинжилдэг. | | | 1 | 1 | | | 2 |
| Суралцагч бүрийн хэрэгцээ, онцлогийг оношлон шинжилж, түүнд нийцүүлэн суралцахуйн түгээмэл загварыг хэрэгжүүлэх тодорхой арга, аргачлалыг дэвшүүлдэг. | | | | 1 | | 1 | 2 |
| Суралцагч бүрийн хэрэгцээ, онцлогт нийцүүлэн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг өгсөн алхмын дагуу боловсруулж, суралцахуйн уян хатан, таатай орчинг бүрдүүлэхийн тулд анги танхимын менежентийг төлөвлөдөг. | | | 1 | | | 1 | 2 |
| Суралцагчийн онцлог, ялгаатай байдалд хүндэтгэлтэй ханддаг, тэдний эрхийг дээдлэн ойлгож харьцах хүсэл эрмэлзэлтэй. | | | | | 1 | | 1 |
| Суралцагч бүрийн хэрэгцээ, онцлогтой холбоотойгоор үүсэх | | | | | 1 | | 1 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| асуудлыг олж харах, түүнийг шийдвэрлэхийн тулд хамтран ажиллаж, олон нийтийн оролцоог хангадаг, шаардлагатай үед бусдаас дэмжлэг авахад бэлэн байдаг. | | | | | | | |
| Нийт | | | | | | | 10 |

**“ОРЧИН ҮЕИЙН БОЛОВСРОЛЫН ОНОЛ, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ” (E.MT601)**
**ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА**

***Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ***

***2. Хичээлээр эзэмших мэдлэг, чадвар, хандлага (CLO):***

1.1. Орчин үеийн боловсролын онол, үзэл баримтлал (тэгш хамруулах, тогтвортой хөгжлийн, насан туршийн, дэлхийн иргэний боловсрол), хөгжлийн чиг хандлагыг нийгмийн шинэчлэлтэй холбон тайлбарлаж, жишээ гаргадаг.
2.1. Орчин үеийн боловсролын үзэл санааг Монголд хэрэгжүүлэхтэй холбоотой эрх зүйн баримт бичиг, хэрэгжилтэд задлан шинжилгээ хийж дүгнэдэг.
2.2. Орчин үеийн боловсролын үзэл санаа, шинэлэг технологийг сургалтад хэрэгжүүлэх талаар шинэ санаа дэвшүүлж, арга замыг тодорхойлдог.
3.1. Боловсролын шинэ үзэл баримтлалд олон ургалч үзлээр ханддаг, өөрийн байр суурийг илэрхийлдэг, аливаад бүтээлч, санаачилгатай хандахад бэлэн байгаагаа харуулдаг.

**3. Үнэлгээний хэлбэр, жин:**

***Хүснэгт 1. Үнэлгээний хэлбэр ба багтаамж***

| № | Үнэлгээний хэлбэр | Эзлэх хувь | Багтаамж |
|---|---|---|---|
| 1 | Ирц, оролцоо | 20% | Ирц: 10 % Лекц семинарын хичээлд ирсэн байдал<br>Оролцоо: 10 % Семинарын тэмдэглэл, багийн ажлын оролцоо, хэлэлцүүлэг удирдсан, асуултад хариулсан байдал зэргийг харгалзан үнэлнэ. |
| 2 | Бие даах ажил | 50% | Бие даах ажлыг хийж гүйцэтгэсэн байдал<br>iv. Судалсан эх сурвалжийн сонголт болон сэдэвтэй уялдсан байдал<br>v. Бичсэн ажлын ерөнхий бүтэц, агуулга, найруулга, үзэл санааны илэрхийлэл<br>vi. Бичлэгийн соёл<br>• Бичлэгийн техник, дизайн<br>• Эш авалт, зүүлт хийх |
| 3 | Явцын үнэлгээ | 30% | Хичээлийн агуулгын дагуу оюутны эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагад гарсан өөрчлөлтийг үнэлнэ.<br>*Өдөр тутмын явцын үнэлгээнд:* Метафор, гарах хуудас, өөрийн үнэлгээний хянах хуудас зэрэг аргачлалыг хэрэглэж, лекц, семинар дахь оюутны идэвх, оролцоог үнэлнэ.<br>*Явцын үр дүнгийн үнэлгээнд:* Сорил, тохиолдлын шинжилгээ, хэлэлцүүлэг, ярилцлага зэрэг аргыг хэрэглэн, хичээлээр |

| | | | |
|---|---|---|---|
| | | | эзэмших мэдлэг, чадвар, хандлагын өөрчлөлтийг үнэлнэ. |

***Хоёр. ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА***

| | |
|---|---|
| **Хичээлийн нэр, код:** | Орчин үеийн боловсролын онол, үзэл баримтлал, E.MT601 |
| **Улирал:** | Дурын |
| **Кредит:** | 2 |
| **Хичээлийн хэлбэр**: | 1:2:0:0:(3) |
| **Заах багш:** | БСАЗ-н тэнхимийн багш нар |
| **Е-мэйл хаяг:** | bayarmaa.g@msue.edu.mn |
| **Ажлын өрөө:** | МУБИС-ийн IX байр 1b тоот |
| **Ажиллах цаг:** | Даваа–Баасан, 9:00 am – 18:00 pm. |
| **ULMS хаяг:** | http://203.212.28.101/index.aspx |

**Үндсэн сурах бичиг**:
Бэгз, Н. (2015). Боловсролын парадигм. Улаанбаатар

**Нэмэлт унших материалууд:**
МУБИС. (2017). Орчин үеийн боловсролын бодлого, менежмент. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл
Пүрэв,О. (2013). Монголын боловсрол, сургалтыг хүмүүншүүлэх онол, арга зүйн зарим асуудал. Улаанбаатар

**Хичээлийн өмнөх холбоо:** Боловсрол судлалын магистрын мэргэжлийн суурь хичээлүүдийг судалж дууссаны дараагаар мэргэшүүлэх заавал судлах хичээл болгож энэхүү хичээлийг судлах болно.

**Хичээлийн товч тодорхойлолт:** "Орчин үеийн боловсролын онол, үзэл баримтлал" хичээл нь боловсрол судлалын магистрантурын сургалтын төлөвлөгөөнд мэргэшүүлэх заавал судлах хичээлүүдийн нэг болж ордог бөгөөд 16 цагийн лекц, 32 цагийн семинар, нийт 48 цаг судлах 2 кредитийн багтаамжтай хичээл юм. Магистрант нь энэхүү хичээлийг судалснаар орчин үеийн боловсрол, түүний хөгжлийн үзэл баримтлалын талаар судалж, задлан шинжлэх, мэдээлэл боловсруулах, асуудлыг дэвшүүлэн шийдвэрлэх арга замыг тодорхойлох зэрэг чадварыг эзэмшихэд чиглэнэ.

**Хичээлийн зорилго:** Энэ хичээлээс магистрант боловсролын орчин үеийн үзэл баримтлал, онолын мөн чанарыг ойлгож, тэдгээрийг амьдрал, сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхэд суралцана.

**Хичээлийн агуулга:** Орчин үеийн боловсролын онол, үзэл баримтлал хичээл нь “Тэгш хамруулах боловсрол”, “Тогтвортой хөгжлийн төлөөх боловсрол”, “Насан туршийн боловсрол”, “Дэлхий  иргэний боловсрол”, “Дижитал эрин үе ба боловсрол” гэсэн таван үндсэн хэсгээс тогтох бөгөөд лекц, семинарын агуулгыг 1-р хүснэгтэд харуулав.

*Хүснэгт 2. Хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө*

| Долоо хоног | Лекц | | Семинар | |
|---|---|---|---|---|
| | Сэдэв | Цаг | Сэдэв | Цаг |
| 1 | Орчин үеийн нийгмийн хөгжил ба боловсролын чиг хандлага | 2 | “Алсын хараа-2050”-ийн “Боловсрол” хэсэгт тэгш хамруулан сургах, насан туршийн боловсрол, суралцагчдын ялгаатай байдлыг хүндэтгэх талаар дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааг ялгах | 4 |
| | | | “Алсын хараа-2050”-ийн “Ногоон хөгжил” хэсэгт тогтвортой хөгжлийн чиглэлээр дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааг ялгах | |
| 2 | Тэгш хамруулах боловсрол, мөн чанар | 2 | Тэгш хамруулах боловсролын эрх зүйн баримт бичгүүдийг шинжлэх | 6 |
| | | | Монгол дахь Тэгш хамруулах боловсролын өнөөгийн байдлын тохиолдлын шинжилгээ | |
| 3 | Тэгш хамран суралцагчид, тэдгээрийн онцлог | 2 | Түрэмгий зан авиртай, анхаарлын дутмагшилтай, хэт хөдөлгөөнтөх эмгэгтэй суралцагчдын онцлогийг харгалзах нь | 4 |
| | | | Суралцахуйн бэрхшээлтэй суралцагчид, тэдгээрийн онцлогийг харгалзах нь | |
| 4 | Тэгш хамруулан сургах зүй/багшлахуй | 2 | Тэгш хамруулах багш, түүний чадамж | 4 |
| | | | Суралцахуйн түгээмэл загвар, түүнийг хэрэгжүүлэх арга зам | |
| 5 | Тогтвортой хөгжлийн төлөөх боловсрол, хөгжлийн чиг хандлага | 2 | Хэлэлцүүлэг: Тогтвортой хөгжлийн төлөөх боловсрол Монголд | 4 |
| 6 | Насан туршийн боловсролын үзэл баримтлал | 2 | Мэтгэлцээн: Насан туршдаа суралцахуйн үзэл баримтлал бидний амьдралд | 4 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 7 | Дэлхийн иргэний боловсрол | 2 | Хэлэлцүүлэг: Яагаад дэлхийн иргэний боловсрол чухал вэ? | 2 |
| 8 | Дижитал эрин үе /МХТ/ ба боловсролын хөгжил | 2 | Дижитал эрин үе боловсролын хөгжилд оруулсан хувь нэмэр<br>Боловсролын хөгжлийн цаашдын чиг хандлага | 4 |
| | **Нийт** | **16** | | **32** |

**Хичээлийн арга зүй:** Тус хичээлийн зохион байгуулахдаа сургалтын идэвхтэй аргыг хэрэглэхээс гадна магистрантын оролцоог дэмжихэд анхаарна. Суралцахуйн тонгоруу аргад суурилна. Тонгоруу сургалтыг дараах үе шаттайгаар зохион байгуулна.




**Хичээлийн үнэлгээ:** Магистрантын идэвх оролцоог семинар болон лекцийн хичээлд оролцсон байдал, тонгоруу аргаар гэртээ гүйцэтгэсэн даалгаврын гүйцэтгэлээр үнэлнэ.

***Хүснэгт 3. Даалгаврын гүйцэтгэлийн шалгуур***

| Даалгаврыг үнэлэх шалгуур | Үзүүлэлт | | |
|---|---|---|---|
| | Хангалттай | Дунд зэрэг | Хангалтгүй |
| Судалсан эх сурвалжийн сонголт болон сэдэвтэйгээ уялдсан байдал | - 5 ба түүнээс дээш эх сурвалж ашигласан<br>- Сонгосон эх сурвалж нь сэдэвтэй уялдсан | - 3-5 эх сурвалж ашигласан<br>- Сонгосон эх сурвалж сэдэвтэй уялдаа холбоо багатай | - 1-2 эх сурвалж ашигласан<br>- Сонгосон эх сурвалж сэдэвтэй холбогдолгүй |
| Даалгаврын бүтэц, агуулга, найруулга, үзэл санааны | - Даалгаврын бүтцийг өөрөө бүтээж, санаачлагатай хандсан | - Даалгаврыг багшийн өгсөн заасврын дагуу гүйцэтгэсэн<br>- Агуулгыг бүрэн | - Даалгаврыг дэс дараалал, логик холбоо багатай гүйцэтгэсэн<br>- Агуулга тодорхой |

| | | | |
|---|---|---|---|
| илэрхийлэл | - Агуулгыг бүрэн багтаасан<br>- Даалгаварт өөрийн үнэлгээ өгч, сайжруулах чиглэлээ олж харсан | бус багтаасан<br>- Даалгаврын өөрийн үнэлгээг хангалттай гүйцэтгэж, алдаагаа харж чадаагүй | бус, дахин гүйцээх шаардлагатай<br>- Даалгаварт өөрийн үнэлгээ хийгээгүй |
| Бичлэгийн соёл | - Бичлэгийн техник, дизайныг шаардлагын дагуу гүйцэтгэсэн<br>- Эшлэл, зүүлтийг оновчтой хэрэглэж, APA форматын дагуу гүйцэтгэсэн | - Бичлэгийн техник, дизайны зарим шаардлагыг хангаагүй<br>- Эшлэл, зүүлтийг хэрэглэсэн боловч APA форматыг баримтлаагүй | - Бичлэгийн техник, дизайны шаардлага хангаж чадаагүй<br>- Эшлэл, зүүлтийг хэрэглэхэд бэрхшээлтэй байсан |

Магистрантын бие даах ажлыг "... боловсролын Монголд хэрэгжиж буй өнөөгийн байдал" сэдвээр бичил судалгаа гүйцэтгэх бөгөөд дараах шалгуурын дагуу үнэлнэ.

*Хүснэгт 4. Бие даах ажлын үнэлгээ*

| № | Шалгуур | Үзүүлэлт |
|---|---|---|
| 1 | Сэдэв сонгосон байдал, үндэслэл | - Тухайн сэдвээр Монголд тулгамдаж буй асуудлыг дэвшүүлсэн эсэх<br>- Сэдэв сонгосон үндэслэлийг асуудалтай холбосон эсэх |
| 2 | Судалгааны аргыг зорилго, зорилттой нийцүүлэн сонгосон байдал | - Баримт бичгийн шинжилгээнд үндэслэн нөхцөл байдлыг тодорхойлсон эсэх<br>- Түүврийг оновчтой сонгож, боловсролын байгууллагад ажиглалт, ярилцлага зэрэг чанарын судалгаа хэрэгжүүлсэн эсэх<br>- Судалгааны бусад аргыг оновчтой сонгож хэрэглэсэн эсэх |
| 3 | Судалгааны мэдээлэл цуглуулж, үр дүнг боловсруулсан байдал | - Судалгааны мэдээллийг бодитой, найдвартай цуглуулсан эсэх<br>- Түүврийн хэмжээг хангасан эсэх<br>- Компьютер болон бусад программ ашиглан судалгааны үр дүнг боловсруулсан эсэх |
| 4 | Судалгааг танилцуулахад бэлтгэсэн байдал | - Судалгааг танилцуулах ppt бэлтгэж, оновчтой хэлбэрээр судалгааны үр дүнг илэрхийлсэн эсэх<br>- Судалгааны үр дүнг бусдад ойлгомжтойгоор |

| | | |
|---|---|---|
| | | тайлбарласан эсэх |
| 5 | Бие даах ажлын өөрийн үнэлгээ | - Бие даах ажилд өөрийн үнэлгээ хийсэн эсэх<br>- Өөрийн үнэлгээнд үндэслэн сайжруулах шаардлагатай хэсгийг тодорхойлсон эсэх<br>- Бие даах ажлыг сайжруулсан эсэх |

**“ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫН ОНОЛ БА ХЭРЭГЛЭЭ” (E.IE502)**
**ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА**

## *Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ*

### *4. Хичээлээр эзэмших мэдлэг, чадвар, хандлага (CLO):*

4.1. Тэгш хамран сургах боловсролын онолын үзэл баримтлал, үнэт зүйл, зарчмын талаар тайлбарладаг.
2.1. Тэгш хамран сургах боловсролын талаарх өөрийн орны болон бусад улс орны хууль эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийдэг.
2.2. Тэгш хамран сургах сургууль, ангийг бүрдүүлэх, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулдаг.
2.3. Суралцахуйн түгээмэл загварыг анги, сургуулийн орчинд хэрэгжүүлэх хувилбар боловсруулдаг.
2.4. Сургалтын хөтөлбөрийг тохируулан өөрчлөх хэрэгцээ шаардлагыг тодорхойлдог.
3.1. Тэгш хамран сургах боловсролыг түгээн дэлгэрүүлэх, орон нутаг, сургуулийн хүрээнд өөрчлөлт хийх хүсэл эрмэлзэлтэй.

### 5. Үнэлгээний хэлбэр, жин:

*Хүснэгт 1. Үнэлгээний хэлбэр ба багтаамж*

| № | Үнэлгээний хэлбэр | Эзлэх хувь | Багтаамж |
|---|---|---|---|
| 1 | Ирц, оролцоо | 20% | Ирц: 10 % Лекц семинарын хичээлд ирсэн байдал<br>Оролцоо: 10 % Семинарын тэмдэглэл, багийн ажлын оролцоо, хэлэлцүүлэг удирдсан, асуултад хариулсан байдал зэргийг харгалзан үнэлнэ. |
| 2 | Бие даах ажил | 50% | 2 бие даах ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:<br>vii. Хууль эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийх<br>viii. Тэгш хамран сургах анги эсвэл сургуулийг бүрдүүлэх төсөл боловсруулах<br>Бие даах ажлыг дараах шалгуураар үнэлнэ.<br>- ажлын агуулга,<br>- логик уялдаа холбоог гаргасан байдал,<br>- бие даалтын ажлын зорилгыг хангасан байдал,<br>- бичиж боловсруулсан байдал,<br>- хийсэн ажлаа хамгаалж буй байдал |
| 3 | Явцын үнэлгээ | 30% | Явцын үнэлгээний 2 бүлэг сэдвийн сорилыг гүйцэтгэнэ. |

**Хоёр.** ***ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА***

| | |
|---|---|
| **Хичээлийн нэр, код:** | Тэгш хамран сургах боловсролын онол ба хэрэглээ, E.IE 502 |
| **Улирал:** | Дурын |
| **Кредит:** | 2 |
| **Хичээлийн хэлбэр**: | 1:2:0:0:(3) |
| **Заах багш:** | Ч.Байгалмаа, E.SN02 |
| **Е-мэйл хаяг:** | ch_baigalmaa@msue.edu.mn |
| **Ажлын өрөө:** | МУБИС-ийн IX байр 1b тоот |
| **Ажиллах цаг:** | Даваа–Баасан, 9:00 am – 18:00 pm. |
| **ULMS хаяг:** | http://203.212.28.101/index.aspx |

**Үндсэн сурах бичиг**:
БШУЯ. Хүүхдийн сан. (2023). Тэгш хамруулах боловсрол. ЕБС-ийн дунд ангийн багш нарт зориулсан мэргэжил дээшлүүлэх сургалтын модуль. Улаанбаатар.

**Нэмэлт унших материалууд:**
МУБИС. Хүүхдийн сан. (2022). Сургалтын үйл ажиллагааг дэмжих тусгай хэрэгцээт боловсролын арга зүй: дунд ангийн жишээн дээр. Улаанбаатар

МУБИС. Хүүхдийн сан. (2022). Сургалтын үйл ажиллагааг дэмжих тусгай хэрэгцээт боловсролын арга зүй: бага ангийн жишээн дээр. Улаанбаатар

БШУЯ. Тэгш хамруулах боловсрол. (2023). V ангийн сурагчдыг бага ангиас дунд ангид дэвшин суралцахад дэмжлэг үзүүлэх арга зүй. Улаанбаатар

**Хичээлийн өмнөх холбоо:**

**Хичээлийн тодорхойлолт:** Энэхүү хичээлийг тусгай хэрэгцээт боловсролын магистрын түвшинд заавал судлах хичээл болгон судална. Нийт 2 кредит бөгөөд магистрантын практик үйл ажиллагаанд үндэслэнэ.

**Хичээлийн агуулга:** Тус хичээл нь “Тэгш хамран сургах боловсролын онолын үзэл баримтлал”, “Тэгш хамран сургах боловсролын хууль эрх зүйн орчин”, “Тэгш хамран сургах боловсролыг хэрэгжүүлэх практик үйл ажиллагаа” гэсэн үндсэн цөм агуулгаас бүрдэнэ. Цөм агуулга болон хичээлийн хүрэх үр дүнгийн хамаарлыг 2-р хүснэгтээр харууллаа.

***Хүснэгт 2. Хичээлийн цөм агуулга ба хүрэх үр дүнгийн хамаарал***

| Хичээлийн цөм агуулга | Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадварууд |
|---|---|
| Тэгш хамран сургах боловсролын онолын үзэл баримтлал | 1.1, 2.4, 3.1 |
| Тэгш хамран сургах боловсролын хууль эрх зүйн орчин | 1.2, 3.1 |
| Тэгш хамран сургах боловсролыг хэрэгжүүлэх практик үйл ажиллагаа | 2.2, 2.3, 2.4 |

Хичээлийн агуулга болон жишиг сэдэвчилсэн төлөвлөгөөг доорх хүснэгтэд харууллаа.

***Хүснэгт 3. Хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө***

| *№* | *Сэдэв* | *Лекц* | *Семинар* |
|---|---|---|---|
| 1 | Тэгш хамран сургах боловсролын онолын үзэл баримтлал | 2 | 4 |
| 2 | Тэгш хамран сургах боловсролын талаарх ОУ-ын болон үндэсний хууль эрх зүйн орчин | 2 | 4 |
| 3 | Тэгш хамран сургах сургууль, ангийн онцлог | 2 | 4 |
| 4 | Ердийн сургуульд сурч буй ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн асуудал ба хамтын ажиллагаа | 2 | 4 |
| 5 | Суралцахуйн түгээмэл загвар, түүнийг хэрэгжүүлэх | 2 | 4 |
| 6 | Сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүйг тохируулан өөрчлөх | 2 | 4 |
| 7 | Сургалтын үр дүн, суралцагчийн ахицыг үнэлэх нь | 2 | 4 |
| 8 | Салбар доторх болон салбар хоорондын хамтын ажиллагаа | 2 | 4 |
| | **НИЙТ** | **16** | **32** |

**Хичээлийн арга зүй:** Тухайн хичээлийн хүрээнд лекц, хэлэлцүүлэг хийх, бие даан уншиж судлах, бүлгээр болон ганцаарчлан дасгал даалгавар гүйцэтгэх зэрэг аргуудыг танхимын сургалтад ашиглана. Түүнчлэн бие даалтын ажил, гэрийн даалгавар зэргээр дамжуулан танхимын сургалтаар судалсан зүйлсийг хийж турших, хэрэглэж ашиглах боломжийг бүрдүүлнэ.

**Хичээлийн үнэлгээ**

Сургалтын журамд заасны дагуу багш оюутныг үнэлэхийн зэрэгцээ оюутнууд тухайн хичээлээр сурч, эзэмшсэн зүйлстээ өөрийн үнэлгээ, дүгнэлт хийнэ. Хичээлээр эзэмшсэн

оюутны мэдлэг, чадвар, хандлагыг МУБИС-ийн сургалтын журмын дагуу үнэлэх ба хичээлийн ирц, оролцоо-20 хувь, 2 удаагийн бие даалтын ажил нийт 50 хувь, явцын 2 удаагийн сорил 30 хувь гэсэн байдлаар үнэлгээг хийнэ.

*Бие даан гүйцэтгэсэн даалгаврыг үнэлэх арга:*

Тус хичээлийн хүрээнд оюутнууд 2 бие даалтын ажил гүйцэтгэх бөгөөд бие даалт тус бүрийг тодорхой шалгуурын дагуу үнэлнэ. 2 бие даалтын ажлын үнэлгээний дундаж оноо нь тухайн хичээлийн ерөнхий үнэлгээний онооны 50 хувийг эзэлнэ. Бие даалтын ажлыг үнэлэхдээ хийсэн ажлын агуулга, логик уялдаа холбоог гаргасан байдал, тус бие даалтын ажлын зорилгыг хангасан байдал, бичиж боловсруулсан байдал, хийсэн ажлаа хамгаалж буй байдал зэргээр үнэлнэ.

*Бие даан гүйцэтгэх ажил 1:* Хууль эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийх

Тэгш хамран сургах боловсролын талаарх өөрийн орны бодлогын баримт бичиг, хууль, дүрэм журмыг судлан өөр бусад 2-3 орныхтой харьцуулан шинжилж, давуу ба сул талуудыг тодорхойлон тайлан бичнэ.

*Бие даан гүйцэтгэх ажил 2:* Тэгш хамран сургах анги эсвэл сургуулийг бүрдүүлэх төсөл боловсруулж, танилцуулна.

**ТЭГШ ХАМРУУЛАХ АНГИЙН МЕНЕЖМЕНТ (E.EA611)**
**ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА**

**Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ**

**Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага (CLO):**

1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг боловсролын тогтолцоонд хэрхэн хангах тухай тайлбарлаж, тэгш хамруулах боловсролын мөн чанар, онцлог, аргазүйн хөгжлийн хандлагын онолын үүднээс тодорхойлдог.

1.2. Тэгш хамруулах боловсролын онолын чиг хандлагыг тайлбарлаж хэрэглэдэг.

2.1. Суралцагчдын ялгаатай байдлыг харгалзсан анги танхимын менежментийн асуудлыг илрүүлж, шийдэх арга замыг эрэлхийлдэг.

2.2. Ялгаатай байдлыг харгалзсан анги танхимын менежментийн зохион байгуулалтын хэлбэр, сургалтын материалыг зөв тодорхойлох, зохион байгуулах, чиглүүлэх эрмэлзэлтэй.

**2. Үнэлгээний жин, хэлбэр**

*Хүснэгт 1. Үнэлэх хэлбэр, жин, багтаамж*

| Дд | Үнэлгээний хэлбэр | Жин | Багтаамж |
|---|---|---|---|
| 1 | Ирц | 20% | - Ирц нь бүртгэлээр тооцож харгалзан оноог өгнө. Хичээлийн 70 хүртэлх хувьд суусан оюутан хичээлийн үнэлгээ тооцуулах эрхтэй. |
| 2 | Идэвх оролцоо | 30%/15+15/ | - Семинарийн хичээлийн идэвх оролцоо, багш болон бусад оюутны үйл ажиллагаанд хэр идэвхтэй оролцож буйгаар тооцно.<br>- СУМС дэх хэлэлцүүлэг, контентийн хандалт статистик |
| 3 | Бие даалтын үнэлгээ | 50%/20+30/ | 2 удаагийн бие даалт гүйцэтгэнэ.Үүнд: Судалгааны материалыг уншиж, стандартын дагуу бичвэрийг боловсруулах, илтгэх |
| Нийт | | 100% | |

**Үнэлгээ:** Багш онолын мэдлэгийг өгч, ирц, семинар хэлэлцүүлгийн оролцоо, бие даалтын ажлуудаар суралцагч нэг бүрийн идэвх оролцоог тооцон, суралцагчийн тэгш хамруулах ангийн менежмент хичээлийн мэдлэг, чадвар, хандлагад гарч буй ахиц дэвшлийг МУБИС-ийн суралцагчийн үнэлэх журмын дагуу үнэлнэ.

**Хоёр. ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

| | |
|---|---|
| **Хичээлийн нэр**: | Тэгш хамруулах ангийн менежмент |
| **Хичээлийн код:** | E.EA611 |
| **Улирал:** | |
| **Хичээлийн задаргаа:** | 2кр 1:2:0:0:3 |
| **Заах багш:** | Б.Сүхболд |
| **Е-мэйл хаяг:** | sukhbold@msue.edu.mn |
| **Утас:** | 88114877 |
| **Ажлын өрөө:** | МУБИС-ийн хичээлийн Ё  байр, 19 тоот |
| **Ажиллах цаг:** | Даваа, Баасан 10:00-17:00 |

**Үндсэн сурах бичиг, гарын авлага:**

D. Odgerel, B. Namiraa (2018) Special education textbook, Theories and practices of supporting children with developmental features strategies, 2018,   Sodpress Publishing Co., UB
Д. Одгэрэл, Ч. Нямдорж (2022)  Тэгш хамруулан сургах боловсролын үндэс, 1 дэх хэвлэл, Адмон ХХК
Д. Одгэрэл (2022) Тэгш хамруулах боловсролын монгол-англи тайлбар толь, Адмон ХХО
Д. Одгэрэл нар (2020) “Сургалтын үйл ажиллагааг дэмжих тусгай хэрэгцээт боловсролын арга зүй, 172 шинэлэг санаа, бага ангийн жишээн дээр, Тошобунзка хэвлэлийн компани
Д. Одгэрэл нар (2022) Сургалтын үйл ажиллагааг дэмжих тусгай хэрэгцээт боловсролын арга зүй, дунд ангийн жишээн дээр, Тошобунка хэвлэлийн компани
М. Нагата нар (2020) “Монгол Танака Бине” оюун ухааны сорил, Онолын гарын авлага, хх 9, Өнгөт талст ХХК, УБ
М. Нагата нар (2020) “Монгол Танака Бине” оюун ухааны сорил, Оноожуулах гарын авлага, хх 10.5, Өнгөт талст ХХК, УБ
М. Нагата нар (2020) “Монгол Танака Бине” оюун ухааны сорил, Сорил авах гарын авлага, хх 14, Өнгөт талст ХХК, УБ
Д. Одгэрэл, Н. Оюунтунгалаг (2020) Зан төрх, танин мэдэхүйн бэрхшээлтэй хүүхдийн талаарх ойлголт, илрүүлэх арга зүй, Бага ангийн багш нарт зориулсан зөвлөмж,УБ
Д. Одгэрэл, Б. Намираа (2018)  Тусгай боловсрол, Хөгжлийн онцлогтой хүүхдийг дэмжих онол, арга зүй, Содпресс ХХК, УБ
D. Odgerel (2019) Assessment of children’s mental abilities, Impress Colour Co.Ltd, UB
D. Odgerel et.al (2019) Inclusive Education Training module for regular school teachers, Impress Colour Co.Ltd, UB
Жадамба, Б. ба бусад (2022). Суралцагчдын ялгаатай байдлыг харгалзсан сургалт. Улаанбаатар.
Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Нээлттэй Нийгэм Форум (2022) Суралцагчдын ялгаатай байдлыг харгалзсан сургалт. Соёмбо Принтинг ХХК

Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Нээлттэй Нийгэм Форум (2022) Суралцагчдын ялгаатай байдлыг харгалзсан анги танхимын менежмент. Соёмбо Принтинг ХХК
Tomlinson,C., & Imbeau,M (2010). Leading and managing a differentiated classroom. ASCD.
Tomlinson, C.A. (1999). The differentiated classroom. Virginia: ASCD

**Нэмэлт ашиглах материал, вэб холбоос:**

D. Odgerel (2017) Some results on survey research of children with special needs in Mongolia' Disability research conference handbook, pp. 42-48, national Rehabilitation Center,UB
https://edulaweu.eu/deliverables/
https://mlsp.gov.mn/uploads/files/hbi_nom2020.pdf
https://www.un.org/en/global-issues/human-rights
https://legalinfo.mn/mn/detail/11711
D.Odgerel (2017) Assessment of mental abilities of children in Mongolia, Забайкальский Государственный Университет, University of Zabaikalks, Chia, Russia
D.Odgerel (2017) Assessment of mental abilities of children in Mongolia, Забайкальский University of Zabaikalks, Chita, Russia
D.Odgerel (2017) Результаты сравнительного исследования положения выпускников окончивших ВУЗы по специальности "ПРЕПОДАВАТЕЛЬ НАЧАЛЬНЫХ КЛАССОВ" Забайкальский Государственный Университет
D. Odgerel, B.Myagmarsaikhan, G. Jargalmaa (2018) Inclusive education for every child in Mongolia project "Assessment of needs survey report" IRIM, Mongolia
D.Odgerel, K.Nomura, D.Bayaraa, G.Enkhjargal, G.Batjargal (2019) "Some results on Tanaka Binet-V intelligence test adaptation; administration and development, International Conference on Efficiency and Effectiveness of Educational Services, MNUE, UB
D. Odgerel (2019) Results on comparative study on assessment system for children with special educational needs, Moscow City University, International Conference "City and Education"
Hiroko Tsuboi, M. Matsumoto, L. Kemppinen, D. Odgerel, Y. Ninomiya, S. Keskinen, E.Keskinen, N.Oyuntungalag, A. Nomura, N. Suzuki, C. Hatagaki, H. Matsumoto, M. Morita "An International Comparison of Happiness in Foreign Children in Japan, Japanese, Finnish and Mongolian Children" (2019), 18th International Congress of ESCAP

**Холбогдох хууль, тогтоомж:**

Боловсролын тухай багц хуулиуд

- НҮБ- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн Конвенци
- Хөдөлмөрийн тухай хууль
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль
- Монгол улсын Их Хурлын тогтоол. Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого батлах тухай. 2015.01.29. Дугаар 12.
- Монгол улсын Засгийн газрын тогтоол. Боловсрол Үндэсний хөтөлбөр 2010-2021. 2010.02.13. Дугаар 31.
- Монгол улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын тушаал. Ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолт батлах тухай. 2007.10.05. Дугаар 351.

**Хичээлийн өмнөх холбоо:** E.EA606, E.IL6178 T.IS618

**Хичээлийн зорилго:** Суралцагчдын ялгаатай байдлыг харгалзан үзэж, сургалтад тэгш хамруулан хүртээмжтэй боловсролын үйл ажиллагаанд оролцуулахдаа сургалтын орчин, анги танхим, хөгжлийн болон зан үйлийн ялгаатай байдлыг харгалзан сургалтыг зохион байгуулах талаар гадаад, дотоодын судлаачдын онолын судалгаа, үр дүн, багш нарын туршлага, сургамж, энэ чиглэлээрх нэмэлт материал зэргийг судалж, тухайн анги танхимын сургалтаар суралцагчид зорилгодоо хэрхэн хүрэх, яаж адил тэгш байдлаар боловсролыг олгох, анги танхимд ялгаатай бүхий суралцагч бүр хэрхэн суралцахуйд сурах тэгш боломж бүрэлдүүлэх байдлаар ангийг хэрхэн зохион байгуулах, тэдгээрийн үйл явц, үр дүнг хэрхэн үнэлэх чиглэлд магистрант нь шинжлэх ухааны мэдлэг, онолын үндэслэлтэй илэрхийлэх, тайлбарлах, судалгааны арга зүйн хүрээнд дүн шинжилгээ хийх, бие даан асуудлыг шийдвэрлэх чадварыг эзэмшинэ.

**Хүснэгт 2.** ***Хичээлээр эзэмших мэдлэг, чадвар ба хичээлийн агуулгын хамаарал***

| **Хичээлийн цөм агуулга** | **Хичээлээр эзэмших мэдлэг, чадвар** |
|---|---|
| Тэгш хамруулах боловсрол, түүний мөн чанар, сургалтын онцлог | CLO 1.1, 1.2 |
| Суралцагчийн ялгаатай байдлыг харгалзсан анги танхим, түүний менежмент | CLO 1.2, 2.1, 2,2 |

**Хүснэгт 3.** ***Хичээлийн жишиг төлөвлөгөө***

| Дд | Сэдэв | Судлах цаг | |
|---|---|---|---|
| | | Лекц | Семинар |
| 1. | Тэгш хамруулах боловсролын тухай ойлголт | 2 | 4 |
| 2. | Тусгай хэрэгцээт суралцагчид ба тэгш хамруулах боловсрол | 2 | 4 |
| 3. | Тэгш хамруулах боловсролын асуудлууд | 2 | 4 |
| 4. | Суралцагчдын ялгаатай байдлыг харгалзсан анги танхимын менежмент | 2 | 4 |
| 5. | Анги танхимд голлон илэрдэг суралцагчдын ялгаатай байдал | 2 | 4 |
| 6. | Хүчин зүйлсийг харгалзах арга зам ба багш нарын хамтын ажиллагаа | 2 | 4 |
| 7. | Суралцагчийн ялгаатай байдлыг харгалзсан анги танхимын менежментийн зохион байгуулалтын хэлбэр | 2 | 4 |
| 8. | Сургалтын материал, туршилтын зарим үр дүн | 2 | 4 |
| **Нийт** | | **16** | **32** |

***Арга зүй*:** Тонгоруу сургалтын арга зүйг голлон ашиглана. Хичээлийн явцад бие даан асуудал шийдвэрлэх, хамтран ажиллах арга зүйд тулгуурлан баримт судалгаа болон

тодорхой жишээнүүдэд дүн шинжилгээ хийх, сургалтын арга зүйд суралцах нөхцөлийг бүрдүүлнэ.

*Хүснэгт 4. Магистрантын бие даан гүйцэтгэх /бие даалтын/ ажил*

| № | Сэдэв | Шалгуур |
|---|---|---|
| 1. | Өөрийн сэдвийн хүрээнд тэгш хамруулах боловсролын талаарх баримт бичгийн шинжилгээ | Боловсролын тогтолцоог хүртээмжтэй болгох, тэгш хамруулах боловсролын үндсэн агуулгын талаарх олон улсын конвенц, бодлогын үзэл санаа, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, хамтын ажиллагаа зэрэгт тоон болон чанарын шинжилгээ хийсэн байдал |
| 2. | Өөрийн сэдвийн хүрээнд бодлогын харьцуулсан судалгаа | Тэгш хамруулах боловсролыг амжилттай хэрэгжүүлсэн орнуудын эрх зүйн баримт бичиг, стратеги төлөвлөлт, нийгмийн хандлага, туршлагыг Монгол улсын жишээтэй харьцуулах, үүнээс чиг хандлага, зорилго агуулга, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хүлээгдэж буй үр дүн, хэрэгжилтийг үнэлэн дүгнэх |
| 3. | Өөрийн сэдвийн хүрээнд тэгш хамруулах боловсролын талаарх бичил бодлого боловсруулах | Тусгай хэргцээтэй суралцагчдыг тэгш хамруулахад тулгарч буй саад бэрхшээл, түүнчлэн бүх нийтийг боловсролд тэгш хамруулахад учирч байгаа хүндрэлүүдийг арилгахад чиглэсэн эрхзүйн болоод санхүүгийн боломжийн талаар мэдээлэл цуглуулж боловсруулсан байдал, санал, дүгнэлт |
| 4. | Өөрийн сэдэвт холбогдох гадаад хэл дээрх бодлогын баримт бичгийн орчуулга | Асуудлын чухал, агуулгын хэрэглээ, монгол орчин нөхцөлд тохирох эсэх талаарх дүгнэлт |
| 5. | Өөрийн сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг | Хэлэлцүүлгийн асуултын боловсруулалт, хэлэлцүүлгийг удирдаж буй байдал, хэлэлцүүлгийн тэмдэглэл, гарсан санал, дүгнэлт, үр дүн |
| 6. | Өөрийн сэдвийн хүрээнд илтгэл, өгүүлэл | Илтгэлийн бүтэц, түлхүүр үгс, асуудал, судлагдсан байдал, онолын үндэслэл, практик ажиглалт, туршилт судалгаа, мэдээ баримтын боловсруулалт, санал дүгнэлт, эх сурвалжийг судалсан байдал |

**Бие даалтын даалгаврын үнэлэх арга:**

**Бие даалт 1.**

*Сэдэв:* Багшийн өгсөн бие даалтын материалыг уншиж, ойлгож, бусдад тайлагнах
*Хэлбэр*: Илтгэл тавих
*Хугацаа***:** IV долоо хоног

*Зорилго*: Боловсролын тогтолцоог хүртээмжтэй болгох, тэгш хамруулах боловсролын үндсэн агуулгын талаарх олон улсын конвенц, бодлогын үзэл санаа, Монгол улсад хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, хамтын ажиллагаа зэрэгт тоон болон чанарын шинжилгээ хийх

*Шалгуур*:

1. Хугацаа 10 оноо /тогтоосон хугацаанаас 2 хоногийн хойно өгөхийг зөвшөөрнө. Хоног бүрт 3 оноо хасна/
2. Агуулгыг бүрэн ойлгосон эсэх /судалгааны ажлыг бүрэн ойлгож, өөрийн зүгээс эргэцүүлэл хийсэн эсэх/ 40 оноо
2. Илтгэлийн бэлтгэл /илтгэлийн бүтэц зохион байгуулалт, ойлгомжтой байдал/ 20
3. Илтгэх чадвар /Оновчтой, цэгцтэй ярих/ 20 оноо
4. Асуултад хариулж буй байдал 10

*Бие даалтын илтгэлийн материалд дараах зүйлс заавал багтсан байна. Үүнд:*

1. Илтгэл бэлдсэн оюутны мэдээлэл
2. Судалгааны товч мэдээлэл /гарчиг, судлаачийн нэр, санхүүжүүлэгч зэрэг/
3. Судалгааны зорилго /үндэслэл, хэрэгцээ, зорилго, судалгааны асуулт/
4. Судалгааны арга зүй /түүвэр, өгөгдөлд хийсэн анализ, цаг хугацаа, орон зайн хүрээ/
5. Судалгааны үр дүн
6. Судалгааны дүгнэлт, санал

Агуулгыг бичиж, илтгэхдээ судалгааны бичвэрийг тэр чигээр нь хуулахгүй, аль болох түлхүүр утгаар оруулж, илтгэнэ. Илтгэлийн материалыг багшид file-р хүлээлгэн өгнө.

**Бие даалт 2**.

*Сэдэв:* Улирлын эцсийн тайлан (term paper)

*Хэлбэр*: Боловсруулах

*Хугацаа*: Хичээл дуусах долоо хоногт

*Зорилго*: Судалгааны арга зүйд суралцах

*Арга зүй*:

- Хичээлийн агуулгатай холбоотой нэг агуулгыг сонгон авч түүнийг, Суралцагчийн ялгаатай байдлыг харгалзсан ангийн менежментийн асуудалтай холбон анализ, дүгнэлт хийж paper бичиж хураалгана.
- Сонгосон сэдвээ урьдчилан багшдаа мэдэгдэх бөгөөд илтгэлийн өмнө заавал багшаас зөвлөгөө авсан байна.
- Өөрийн санааг тодорхой гарсан байхаар дэс дараатай, шүүмжлэлт байдлаар бичнэ.
- Paper нь удиртгал (зорилго), үндсэн хэсэг (онолын хэсэг), арга зүй, хүлээгдэж буй үр дүн гэсэн агуулгаар бичигдсэн байна.
- А4-ийн хэмжээтэй 5-10 хуудсанд багтаан бичнэ.

***Зорилго***: Судалгааны ажлын арга барилд суралцах, хичээлийн агуулгыг бататгах

***Үйл явц***:

- Сэдвээ сонгох
- Материал судлах, эх сурвалж хайх
- Боловсруулах
- Бичвэр бичих

***Шалгуур***:

- Тогтоосон хугацаанд өгсөн эсэх /10 оноо/
- Сэдвээ зөв тодорхойлсон эсэх /10 оноо/
- Зорилгоо тодорхой гаргаж өгсөн эсэх /10 оноо/
- Онолын хэсгийг судалсан байдал /20 оноо/
- Арга зүйгээ тодорхой гаргасан эсэх /10 оноо/
- Сэдэв, зорилго, арга зүй хоорондоо уялдаатай эсэх /10 оноо/
- Судалсан материал /10 оноо/
- Хүлээж буй үр дүнг тодорхойлж бичсэн эсэх /10 оноо/
- Судалгааны ажлын загвар, стандарт хангасан байдал /10 оноо/

***Feedback***:

Багш даалгаврыг хүлээн авсны дараа 14 хоногийн дотор хариу зөвлөмжийг бичиж, и-мэйлээр хариу явуулна. (Хичээлийн эцсийн дүнгийн хамт)

***Term paper бичих загвар***:

А4-ын хэмжээтэй цаасан дээр бичиж багшийн e-mail хаягаар ирүүлнэ. Илгээхдээ file-ийн нэрийг оюутан өөрийн нэр, овгийн эхний үсгийн хамт галиглаж бичнэ. Жишээ нь: Sukhbold.B,

**Судалгааны ажлын нэр**

Огноо Оюутны нэр (код)

***Судалгааны зорилго*** (уг сэдэв яагаад чухал болох, тэгвэл энэ судалгаа ямар зорилго дэвшүүлж байгаа, энэ зорилгод хүрэхийн тулд ямар судалгааны асуулт дэвшүүлсэн)............

***Онолын хэсэг*** (Судалгааны зорилгод хүрэх шаардлагатай мэдээлэлтэй ажиллаж чадсан байх)

***Судалгааны арга зүй*** (Судалгааны явц, түүврийн сонголт, судалгааны

багаж боловсруулах тухай, үр дүнг хэрхэн боловсруулах)............
***Судалгааны хүлээгдэж буй үр дүн*** ...........
***Ном зүй***...............

Бичвэрийг дараах загвар, стандартыг баримталж бичнэ.

- Үсгийн фонт, хэмжээ: Times New Roman-11,
- Мөр хоорондын зай: At least 11pt, догол мөр 0.5см
- Бүлэг, дэд бүлгийн гарчигийг догол мөрнөөс bold-р бичнэ.
- Хуудасны хэмжээ: A4, top 2cm, bottom 2cm, right 2cm, left 2cm
- Хүснэгт: хүснэгтийн гарчиг баруун дээд хэсэгт, үсгийн хэмжээ 11, хүснэгт дэх агуулгын үсгийн хэмжээ 10pt өндөртэй
- Зураг: зургийн гарчиг доод төв хэсэгт, үсгийн хэмжээ 11
- Ишлэл, зүүлт, ном зүй: APA style-ийн дагуу (бие даан судлах)

**“ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛ” (E.IE302) ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА**

***Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ***

***6. Хичээлээр эзэмших мэдлэг, чадвар, хандлага (CLO):***

1.1 Тэгш хамран сургах боловсролын үзэл баримтлал, зарчим, үнэт зүйл, эрх зүйн зохицуулалтын талаар тайлбарладаг.
1.2 Суралцахуйн түгээмэл загвар, түүний мөн чанарыг эх сурвалж ашиглан тодорхойлдог.
1.1 Суралцагчдын ялгаатай хэрэгцээг тодорхойлж, түүнд тулгуурлан сургалтын үйл ажиллагааг төлөвлөдөг.
1.2 Тэгш хамран сургах багшлахуй ба суралцахуйг дэмждэг.
1.3 Ялгаатай хэрэгцээтэй суралцагчдын ахиц амжилтыг үнэлэх аргуудыг хэрэглэдэг.
3.1 Суралцагчдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, түүнийг мэргэжлийн үйл ажиллагаандаа тусган авч үзэхийн ач холбогдлыг ухамсарласан.
3.2 Бусад багш нар, эцэг эх, мэргэжилтнүүдтэй хамтран ажиллахын чухлыг ойлгож ухамсарласан.

**7. Үнэлгээний хэлбэр, жин:**

*Хүснэгт 1. Үнэлгээний хэлбэр ба багтаамж*

| № | Үнэлгээний хэлбэр | Эзлэх хувь | Багтаамж |
|---|---|---|---|
| 1 | Ирц, оролцоо | 20% | Ирц: 10 % Лекц семинарын хичээлд ирсэн байдал<br>Оролцоо: 10 % Семинарын тэмдэглэл, багийн ажлын оролцоо, хэлэлцүүлэг удирдсан, асуултад хариулсан байдал зэргийг харгалзан үнэлнэ. |
| 2 | Бие даах ажил | 50% | Бие даах ажлаас нэгийг сонгон гүйцэтгэнэ. Үүнд:<br>1. Суралцахуйн ялгаатай сурагчийн эцэг, эх асран хамгаалагчтай биечлэн уулзаж, тэдэнд тулгамдаж буй асуудал, хүүхэдтэйгээ ажиллах, хөгжлийг дэмжихэд тулгарч буй бэрхшээл, тэдний санал хүсэлтийг тодорхойлох ярилцлага хийж, дүгнэлт бичнэ.<br>2. Тэгш хамран сургаж буй ЕБС-ийн захирал, нийгмийн ажилтан, багшийн туршлагыг судлах, багшийн нэг өдрийн сургалтын үйл ажиллагааг ажиглаж, сурагч бүрийн суралцахуйг дэмжих арга барилд дүгнэлт хийнэ.<br>3. Ялгаатай хэрэгцээтэй суралцагчийн бодит тохиолдолд суурилсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө |

| | | | |
|---|---|---|---|
| | | | боловсруулах. Энэ хүрээнд суралцагчийн талаарх бодит байдалтай танилцаж ялгаатай хэрэгцээтэй суралцагчтай нэг ба түүнээс дээш уулзалт хийсэн байна.<br>4. Бодит тохиолдолд тулгуурлан ялгаатай хэрэгцээтэй суралцагчийн онцлог хэрэгцээнд тулгуурлан хөтөлбөрийн тохиргоо хийнэ. Хөтөлбөрийн тохиргоог хэрхэн хийсэн талаар дүн шинжилгээ, дүгнэлт бичнэ. |
| 3 | Явцын үнэлгээ | 30% | Явцын үнэлгээний 2 бүлэг сэдвийн сорилыг гүйцэтгэнэ. |

**Хоёр.** ***ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА***

| | |
|---|---|
| **Хичээлийн нэр, код:** | Тэгш хамруулах боловсрол, E.IE 302 |
| **Улирал:** | Дурын |
| **Кредит:** | 2 |
| **Хичээлийн хэлбэр**: | 2:2:0:0 (5); 3 кредит |
| **Заах багш:** | Ч.Байгалмаа, E.SN02 |
| **Е-мэйл хаяг:** | ch_baigalmaa@msue.edu.mn |
| **Ажлын өрөө:** | МУБИС-ийн IX байр 1b тоот |
| **Ажиллах цаг:** | Даваа–Баасан, 9:00 am – 18:00 pm. |
| **ULMS хаяг:** | http://203.212.28.101/index.aspx |

**Үндсэн сурах бичиг**:
БШУЯ. Хүүхдийн сан. (2023). Тэгш хамруулах боловсрол. ЕБС-ийн дунд ангийн багш нарт зориулсан мэргэжил дээшлүүлэх сургалтын модуль. Улаанбаатар.

**Нэмэлт унших материалууд:**
МУБИС. Хүүхдийн сан. (2022). Сургалтын үйл ажиллагааг дэмжих тусгай хэрэгцээт боловсролын арга зүй: дунд ангийн жишээн дээр. Улаанбаатар

МУБИС. Хүүхдийн сан. (2022). Сургалтын үйл ажиллагааг дэмжих тусгай хэрэгцээт боловсролын арга зүй: бага ангийн жишээн дээр. Улаанбаатар

БШУЯ. Тэгш хамруулах боловсрол. (2023). V ангийн сурагчдыг бага ангиас дунд ангид дэвшин суралцахад дэмжлэг үзүүлэх арга зүй. Улаанбаатар
**Хичээлийн өмнөх холбоо:**

**Хичээлийн тодорхойлолт:** Энэхүү хичээл нь “Тусгай хэрэгцээт боловсрол, багш”, “Насан туршийн боловсрол, багш” мэргэжлээр суралцаж буй бакалаврын оюутнуудын заавал судлах хичээл болно.

**Хичээлийн зорилго:** Тус хичээлээр тэгш хамран сургах боловсролын үзэл санааг практикт бодитой, үр дүнтэй хэрэгжүүлэх, ялгаатай хэрэгцээтэй суралцагчдад боловсролын үйлчилгээ үзүүлэхэд дэмжлэг үзүүлэх арга зүйн талаар судална.

**Хичээлийн агуулга:** Хичээл нь "Тэгш хамран сургах боловсролын тухай ойлголт", "Тэгш хамран сургах багшлахуй ба суралцахуйд үзүүлэх дэмжлэг", Тэгш хамран сургах боловсрол дахь хамтын ажиллагаа "" гэсэн цөм агуулгаас тогтох бөгөөд хичээлийн хүрэх үр дүнтэй хэрхэн хамаарч байгааг 2-р хүснэгтээр харууллаа.

***Хүснэгт 2. Хичээлийн цөм агуулга ба хүрэх үр дүнгийн хамаарал***

| Агуулгын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг/Хичээлийн төлөвлөлт | Хичээлээр эзэмших мэдлэг, чадвар |
|---|---|
| Тэгш хамран сургах боловсролын тухай ойлголт | 1.1, 3.1 |
| Тэгш хамран сургах багшлахуй ба суралцахуйд үзүүлэх дэмжлэг | 1.2, 2.1, 2.2, 2.3 |
| Тэгш хамран сургах боловсрол дахь хамтын ажиллагаа | 2.1, 2.2, 3.2 |

Хичээлийн агуулга болон жишиг сэдэвчилсэн төлөвлөгөөг доорх хүснэгтэд харууллаа.

***Хүснэгт 3. Хичээлийн жишиг сэдэвчилсэн төлөвлөгөө***

| № | Лекц | Цаг | Семинар | Цаг |
|---|---|---|---|---|
| 1. | ТХСБ-ын зарчим, үнэт зүйл, эрх зүйн зохицуулалт | 2 | ТХСБ-ын зарчим, үнэт зүйл, эрх зүйн зохицуулалт | 2 |
| 2. | Тэгш хамруулах сургууль ба анги | 2 | Тэгш хамруулах сургууль ба анги | 2 |
| 3. | Суралцагчийн ялгаатай хэрэгцээ | 2 | Суралцагчийн ялгаатай хэрэгцээ | 2 |
| 4. | Суралцагчийн ялгаатай хэрэгцээг тодорхойлох, үнэлэх арга зүй | 2 | Суралцагчийн ялгаатай хэрэгцээг тодорхойлох, үнэлэх арга зүй | 2 |
| 5. | Суралцахуйн түгээмэл загварт тулгуурлан хичээлийн хөтөлбөр боловсруулах | 2 | Суралцахуйн түгээмэл загварт тулгуурлан хичээлийн хөтөлбөр боловсруулах | 2 |
| 6. | Суралцахуйн түгээмэл загвар ба сургалтын арга зүй | 2 | Суралцахуйн түгээмэл загвар ба сургалтын арга зүй | 2 |
| 7. | Судлагдахууны онцлогт тулгуурлан хөтөлбөрийн тохиргоо хийх | 2 | Судлагдахууны онцлогт тулгуурлан хөтөлбөрийн тохиргоо хийх | 2 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 8. | UDL-д суурилсан сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах | 2 | UDL-д суурилсан сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах | 2 |
| 9. | Дэмжлэгийн систем MTSS | 2 | Дэмжлэгийн систем MTSS | 2 |
| 10. | Ганцаарчилсан сургалт, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө | 2 | Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах | 2 |
| 11. | Сургалтын ахицыг UDL ашиглан үнэлэх | 2 | Сургалтын ахицыг UDL ашиглан үнэлэх | 2 |
| 12. | Сургалтын үр дүнг үнэлэх | 2 | Сургалтын үр дүнг үнэлэх | 2 |
| 13. | СӨБ-Бага-Суурь боловсролын шилжилтийн үеийн дэмжлэг | 2 | СӨБ-Бага-Суурь боловсролын шилжилтийн үеийн дэмжлэг | 2 |
| 14. | Суурь – Бүрэн дунд – МБ – Хөдөлмөр эрхлэх шилжилтийн үеийн дэмжлэг | 2 | Суурь – Бүрэн дунд – МБ – Хөдөлмөр эрхлэх шилжилтийн үеийн дэмжлэг | 2 |
| 15. | Боловсролын салбар дахь хамтын ажиллагаа | 2 | Боловсролын салбар дахь хамтын ажиллагаа | 2 |
| 16. | Салбар хоорондын хамтын ажиллагаа | 2 | Салбар хоорондын хамтын ажиллагаа | 2 |
| | **Нийт** | **32** | **Нийт** | **32** |

**Хичээлийн арга зүй:** Тухайн хичээлийн хүрээнд лекц, хэлэлцүүлэг хийх, бие даан унших судлах, бүлгээр болон ганцаарчлан дасгал даалгавар гүйцэтгэх, бүтээлч ажил, төсөлт ажил зэрэг аргуудыг танхимын сургалтад ашиглана. Түүнчлэн бие даалтын ажил, гэрийн даалгавар зэргээр дамжуулан танхимын сургалтаар судалсан зүйлсийг хийж турших, хэрэглэж ашиглах боломжийг бүрдүүлнэ.

**Хичээлийн үнэлгээ:** Сургалтын журамд заасны дагуу багш оюутныг үнэлэхийн зэрэгцээ оюутнууд тухайн хичээлээр сурч, эзэмшсэн зүйлстээ өөрийн үнэлгээ, дүгнэлт хийнэ. Хүүхдийн боловсрол хичээлээр оюутны эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг МУБИС-ийн захирлын 2014 оны 01 тоот тушаалын хавсралт сургалтын журмын 4.6-д заасны дагуу үнэлэх ба хичээлийн ирц, оролцоо-20 хувь, 2 удаагийн бие даалтын ажил нийт 50 хувь, явцын 2 удаагийн сорил 30 хувь гэсэн байдлаар үнэлгээг хийнэ.

**Бие даан гүйцэтгэсэн даалгаврыг үнэлэх арга:**

Тус хичээлийн хүрээнд оюутнууд 2 бие даалтын ажил гүйцэтгэх бөгөөд бие даалт тус бүрийг тодорхой шалгуурын дагуу, тохирох оноогоор үнэлнэ. 2 бие даалтын ажлын үнэлгээний дундаж оноо нь тухайн хичээлийн ерөнхий үнэлгээний онооны 50 хувийг

ээзэлнэ. Бие даалтын ажлыг үнэлэхдээ хийсэн ажлын агуулга, логик уялдаа холбоог гаргасан байдал, тус бие даалтын ажлын зорилгыг хангасан байдал, бичиж боловсруулсан байдал, хийсэн ажлаа хамгаалж буй байдал зэргээр үнэлнэ.

Бие даалтын хүрээнд дараах зүйлээс сонгон хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Суралцахуйн ялгаатай сурагчийн эцэг, эх асран хамгаалагчтай биечлэн уулзаж, тэдэнд тулгамдаж буй асуудал, хүүхэдтэйгээ ажиллах, хөгжлийг дэмжихэд тулгарч буй бэрхшээл, тэдний санал хүсэлтийг тодорхойлох ярилцлага хийж, дүгнэлт бичнэ.
- Тэгш хамран сургаж буй ЕБС-ийн захирал, нийгмийн ажилтан, багшийн туршлагыг судлах, багшийн нэг өдрийн сургалтын үйл ажиллагааг ажиглаж, сурагч бүрийн суралцахуйг дэмжих арга барилд дүгнэлт хийнэ.
- Ялгаатай хэрэгцээтэй суралцагчийн бодит тохиолдолд суурилсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах. Энэ хүрээнд суралцагчийн талаарх бодит байдалтай танилцаж ялгаатай хэрэгцээтэй суралцагчтай нэг ба түүнээс дээш уулзалт хийсэн байна.

Бодит тохиолдолд тулгуурлан ялгаатай хэрэгцээтэй суралцагчийн онцлог хэрэгцээнд тулгуурлан хөтөлбөрийн тохиргоо хийнэ. Хөтөлбөрийн тохиргоог хэрхэн хийсэн талаар дүн шинжилгээ, дүгнэлт бичнэ

**“БИЕИЙН ТАМИРЫН-ЫН ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛ” (A.IE504)**
**ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА**

## Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ

**Хичээлээр эзэмших мэдлэг, чадвар, хандлага [CLO]:**

1.1 Биеийн тамирын тэгш хамруулах боловсрол ба боловсролын тогтолцооны орчин үеийн шинэчлэгдэж буй хандлага, түүнтэй холбогдох үндсэн ухагдахууныг тодорхойлж, учир шалтгааныг таньж мэддэг.

1.2 Боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхэд, тэдний талаар эрдэмтдийн үзэл хандлагатай танилцаж өөрийн дүгнэлт гарган биеийн тамирын жишээгээр баталж нотолдог.

1.3 Биеийн тамирын тэгш хамруулах сургалт суралцах таатай орчин бүрдүүлэхэд гэр бүл олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх арга замыг тодорхойлдог.

2.1 Хүүхэд хэрхэн суралцаж, хөдөлгөөний чадвараа нэмэгдүүлдэг талаар хүүхдийн өдөр тутмын амьдралын болон биеийн тамир, спортын жишээгээр тайлбарлан нотолдог.

2.2 Биеийн тамирын тэгш хамруулан сургах сургалт, сургалтын таатай орчин бүрдүүлэхэд тулгардаг бэрхшээлийг орон нутгийн жишээгээр тайлбарладаг, шийдэж болох боломжийг тодорхойлж, хэлэлцэж шийдвэр гаргадаг.

2.3 Биеийн тамирын тэгш хамруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлж, биеийн тамир спортын жишээн дээр хэлэлцдэг

2.4 Боловсролын үйлчилгээнд хамрагддаггүй хүүхдийн талаар тохиолдлын жишээн дээр ажиллаж анализ хийн учир шалтгааныг тодорхойлдог

3.1 Анги бүлэгтэй хамрагдан ирсэн хүүхэд бүрийн хөгжлийн онцлог, хэрэгцээг судлан таньж мэдэх, үнэлгээ хийснээр хүүхэд бүрийн хөгжлийн ялгаанд хүндэтгэлтэй ханддаг

3.2 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн биеийн тамир спортын тусгай хэрэгцээг хангах чадвар, тэдний хэрэгцээнд нийцсэн асуудлыг шийдвэрлэх, суралцах таатай орчин, хэрэглэгдэхүүнийг бүрдүүлдэг

## 2. Үнэлгээний хэлбэр, жин

*Хүснэгт 1. Үнэлгээний хэлбэр ба багтаамж*

| № | Үнэлгээний хэлбэр | Эзлэх хувь | Багтаамж |
|---|---|---|---|
| 1 | Ирц, оролцоо | 20% | Лекц, семинарын ирц, оролцоог харгалзана. |
| 2 | Бие даах ажил | 50% | I бүлгийн агуулгын хүрээнд гүйцэтгэх бие даах ажил |

| | | | |
|---|---|---|---|
| | | | 25%<br>II бүлгээр гүйцэтгэх бие даах ажил 25% |
| 3 | Явцын үнэлгээ | 30% | Хоёр удаа явцын үнэлгээ хийж, тус бүр 15% байхаар үнэлнэ. |

**Хоёр. ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

**Хичээлийн нэр:** **БТ-ЫН** ТЭГШ ХАМРУУЛАХ **БОЛОВСРОЛ,** A.IE504

**Судлах улирал:** Намар

**Хичээлийн задаргаа**: 1:2:0:0(3), **2** кредит

**Сургалт явуулах хэлбэр:** Танхим

**Заах багш:** Ш.Энхбүрэн

**Үндсэн сурах бичиг**:

Хаяаши Кензо (2006). “Тэгш хамруулах боловсрол”. Улаанбаатар

Одгэрэл. Д., бусад., (2016). “Тэгш хамруулах боловсрол”. Улаанбаатар. Мөнхийн үсэг ХХК.

**Нэмэлт унших материалууд:**

Дорждамба., Ш. (1993). “Сэтгэцийн өвчнүүд” Улаанбаатар

Цэвээнлхаазал. Я., Алтанхуяг, Ц. (2005). “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн сургуульд сургах арга зүй” II дэвтэр. Улаанбаатар: УБИС-Багшийн сургууль.

Жадамба. Б., бусад., (2010). Хүчирхийлэлгүй сургууль. Модуль 9. Улаанбаатар

Жадамба. Б., бусад., (2010). Хүүхдийн эрхийн боловсрол. Улаанбаатар

Бурмаа. Б., бусад., (2011). “Тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг ЕБ-ын 12 жилийн сургалтын хөтөлбөрт тусгах нь”. Улаанбаатар

Одгэрэл. Д., Намираа, Б. (2018). Тусгай боловсрол. Улаанбаатар: Сод пресс ХХК.

Орчуулга Наранцэцэг. Д нар., (2018). “Тусгай хэрэгцээт боловсролын үндэс”. Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК

Батцэнгэл, Г., (2018). “Тусгай хэрэгцээт боловсрол” 2 дахь хэвлэл. Улаанбаатар.

Батцэнгэл. Г., (2018). Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургах сэтгэл зүйн үндэс. нэмж засварласан 3 дахь хэвлэл. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК.

Жадамба. Б., бусад., (2022). “Суралцагчийн ялгаатай байдлыг харгалзсан сургалт”. Улаанбаатар. Соёмбо принтинг ХХК

Жадамба. Б., бусад., (2022). “Суралцагчийн ялгаатай байдлыг харгалзсан анги танхимын менежмент”. Улаанбаатар. Соёмбо принтинг ХХК

**Хичээлийн өмнөх холбоо:**

**Хичээлийн товч тодорхойлолт:**
**АГуулгын хувьд:** Тэгш хамруулах боловсролын үндсэн ойлголт ухагдахуун, түүхэн хөгжил, тэгш хамруулах боловсролын зарчим, боловсролын уламжлал ба биеийн тамирын тэгш хамруулах боловсролын тогтолцооны ялгаа онцлог, тэгш хамруулах сургууль, ангийн зохион байгуулалт, тусгай боловсролын үйлчилгээний хэлбэр, бүтэц зохион байгуулалтын талаар судлах, ердийн сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний төрөл хэлбэр, түүнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ганцаарчилсан сургалтын хөтөлбөртэй уялдуулан хэрхэн зохион байгуулах, арга замыг судлах, үнэлэх талаар судална.

**Арга зүйн хувьд:** Суралцагч бүрийн бүтээлч, шүүмжлэлт сэтгэлгээ, бие даан суралцах, академик чадварт тулгуурлан, асуудлыг шийдвэрлэх, хамтран ажиллах, харилцан ярилцах, илтгэх чадвараа сайжруулах, мэдээлэл боловсруулах, судалгаа шинжилгээ хийх, судалгааны арга зүйд суралцах "Оюутан төвт" сургалтыг зохион байгуулан оюутны суралцахад нь хувь нэмэр оруулна.

**Хичээлийн зорилго:**

Суралцагч Тэгш хамруулах боловсролын онол зарчимд тулгуурлан бага насны хүүхдийн нас, хувийн онцлог, хэрэгцээнд нийцсэн хүүхэд бүрийг хөгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах онол арга зүйн мэдлэгтэй болж, улмаар түүнийг амьдралд хэрэглэх чадвар эзэмших, суралцагчдын хэрэгцээг нь хангалзан сурч хөгжих нөхцөл боломжоор хангах эрмэлзэл, хандлага мэргэжлийн чиг баримжаатай болно.

***Хүснэгт 1. Хичээлээр эзэмших мэдлэг, чадвар ба хичээлийн цөм агуулгын хамаарал***

| **Хичээлийн цөм агуулга** | **Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадварууд** |
|---|---|
| Тэгш хамруулах боловсрол /БТ-спорт/ | [1.1], [1.2], [2.2], [2.3], [3.1], [3.2] |
| Тусгай хэрэгцээт боловсрол | [1.1], [1.2], [2.1], [2.4], [3.1], [3.2] |
| Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө | [1.1], [1.2], [2.1], [2.2], [2.3], [2.4], [3.1], [3.2] |

***Хүснэгт 2. Хичээлийн жишиг төлөвлөгөө***

| **Долоо хоног** | **Бүлэг сэдэв** | **Сэдэв** | **Цаг** | |
|---|---|---|---|---|
| | | | **Лекц** | **Сем** |
| 1-3 | Бүлэг 1 Тэгш хамруулах боловсрол | Тэгш хамруулах боловсролын өнөөгийн байдал чиг хандлага | 2 | |
| | | Хичээлийн тухай танилцуулга, тэгш хамруулах боловсролын талаарх оюутны үзэл хандлагыг сонжих дасгал ажиллах | | 2 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Үндсэн ухагдахуунуудыг тодорхойлон хэлэлцэж, утгыг тайлбарлах | | 2 |
| | | Тэгш хамруулах боловсролын зарчим, боловсролын уламжлал ба тэгш хамруулах боловсролын тогтолцооны ялгаа онцлог | 2 | |
| | | Үл тоох, тусгаарлах, интеграцчилах, тэгш хамруулах сургахыг ялгаа ба ижил тал | | 2 |
| | | Бага насны хүүхэд хэрхэн суралцдаг талаар өөрийн бага насанд тохиолдсон кейс дээр ажиллаж тодорхойлох | | 2 |
| | | Тэгш хамруулах сургууль, ангийн зохион байгуулалт, орчин | 2 | |
| | | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ангилал, үр дүнтэй харилцах талаар онол арга зүйн холбоо хамаарлыг тайлбарлах, нотлох | | 2 |
| | | Бүлэгт хамрагдаж буй харилцан адилгүй чадварын түвшин, ялгаатай суралцах хэрэгцээтэй хүүхдүүдийг тэгш хамруулан сургах, суралцах таатай орчныг бүрдүүлэх, сургалтыг үр дүнтэй зохион байгуулах арга технологийг хэрэгжүүлж буйг жишээгээр үзүүлэх | | 2 |
| 4-5 | Бүлэг 2 Тусгай хэрэгцээт боловсрол | Тусгай боловсролын түүхэн хөгжил, үе шат | 2 | |
| | | Биеийн тамир, анагаах ухаан, ёс зүй, нийгмийн, хувь хүнд төвлөрсөн хандлага тус бүрийн ижил ба ялгаатай талыг тодорхойлох | | 2 |
| | | Хүүхдийн хөгжих таатай орчныг бүрдүүлэх хэрэгцээ шаардлагыг жишээгээр тайлбарлаж батлах | | 2 |
| | | Тусгай боловсролын үйлчилгээний хэлбэр, бүтэц, зохион байгуулалт | 2 | |
| | | “Тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхэд” гэсэн нэр томьёог тайлбарлах, жишээгээр нотлох | | 2 |
| | | “Тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхэд” суралцах таатай орчныг бүрдүүлэх нь яагаад чухал байдаг талаар жишээгээр тайлбарлах | | 2 |
| 6-8 | Бүлэг 3 Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө | ЕБС-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сургалтыг зохион байгуулах арга зам | 2 | |
| | | Өөрийн орон нутгийн жишээгээр саад бэрхшээлийг (Хүүхэд, гэр бүл, цэцэрлэг, олон нийт) тохиолдын жишээгээр илэрхийлж, шийдэж болох боломжийг тодорхойлж, хэлэлцэж, шийдвэр гаргах | | 2 |
| | | Боловсролын үйлчилгээнд хамрагддаггүй хүүхдийн талаар тохиолдлын жишээн дээр ажиллаж, шалтгааныг тогтоох | | 2 |
| | | ГСХ-ийг ердийн боловсролын үйлчилгээтэй уялдуулан зохион байгуулах, хэрэгжүүлэх | 2 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Анги бүлэгт суралцаж буй бүх хүүхэд сэтгэл хангалуун, баяр баясгалантай суралцах орчин | | 2 |
| | | Эрт бага насны хүүхдийн гэр бүлийн оролцоо, түүнийг дэмжих, харилцах талаар тайлбарлах, нотлох | | 2 |
| | | ГСХ-ийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт ба хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн амжилт | 2 | |
| | | Биеийн тамирын тэгш хамруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлж хэлэлцэх | | 2 |
| | | Хүүхэд хэрхэн суралцаж, чадвараа нэмэгдүүлдэг талаар хүүхдийн өдөр тутмын болон биеийн тамир, спортын амьдралын жишээгээр тайлбарлах, нотлох | | 2 |
| **Бүгд** | | | **16** | **32** |

**Арга зүй:**

Сургалтыг хөтөлбөрийн цагийн задаргаанд заасны дагуу лекц, семинарын хэлбэрээр явуулах ба лекцийн хичээлийг багшийн бэлтгэсэн үзүүлэх материалаас гадна оюутнуудын өөрсдийн бүтээлч оролцоо санал, хэлэлцүүлэг дээр тулгуурлан тэдгээрийн үр дүнг харуулсан жишээгээр дэмжинэ.

Семинарын хичээлийг оюутнуудыг бие даасан болон хамтран суралцах хэлбэрээр ажиллуулан шаардлагатай үед онолын болон практик зөвлөгөө өгч суралцуулна. Нэгж хичээлийг өмнөх болон дараагийн үйл ажиллагаа холбоотой нь уялдуулахад анхаарч ижил төстэй бөгөөд шинэ агуулгад уялдуулсан дасгал дээр ажиллуулах.

Хичээлийн арга зүйд анализ, синтез, жишиж харьцуулах, агуулгыг өргөсгөн гүнзгийрүүлэх, алдааны шинжилгээ хийх, асуудлын гүн рүү нэвтрэх аргуудын аль тохиромжтойг сонгон ашиглах.

**Үнэлгээ:**

16 цагийн лекц, 32 цагийн семинар хичээлийн ирцийг 20% тооцно.

*Бие даан гүйцэтгэх даалгаврын үнэлгээ:*

Бие даах ажлаа хийж гүйцэтгэсэн байдал:

I бие даалт 25%: I бүлгийн агуулгын хүрээнд оюутан бүр өөр өөрийн судалсан тэгш хамруулах боловсролын талаарх ойлголт “Биеийн тамирын тэгш хамруулах боловсрол” сэдэвт хэлэлцүүлэг хийх даалгавар юм.

II бие даалт 25%: II бүлгийн агуулгын хүрээнд оюутны сурсан, мэдсэн зүйлийг шалгаж болохуйц даалгавар “Боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхэдтэй танилцаж өөрийн дүгнэлтийг хийж, түүнийгээ баталж нотлох даалгавар юм.

*Явцын үнэлгээ:*

I явцын шалгалт 15%: I-II бүлгийн хүрээнд хичээлээр эзэмшсэн мэдлэгийн талаарх ярилцлага

II явцын шалгалт 15%: I-III бүлгийн хүрээнд “Бичил судалгаа” бие даан хичээл төлөвлөх

**“БОЛОВСРОЛЫН ХҮРТЭЭМЖ БА ЧАНАР” (Е.ЕА606) ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА**

# I. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ

## 1. Хичээлээр эзэмших мэдлэг, чадвар, хандлага (CLO)

*1.1. Тэгш бус байдлын талаарх нийгмийн онол ба судалгааны чиг хандлага, үндсэн ойлголтуудыг судлах, тайлбарлах, харьцуулан дүгнэдэг*
*1.2. Тэгш хамрах боловсролын талаарх олон улсын конвенц, гадаадын болон үндэсний хэмжээний бодлогын баримт бичиг, эрх зүйн талаар мэдэх, харьцуулах, үнэлгээ хийдэг*
*1.3. Нийгмийн гарал, хүйс, үндэс угсаанаас шалтгаалсан нийгэм, боловсролын тэгш бус байдлын талаар сүүлийн үеийн судалгааны тоймуудад анализ хийж тэгш бус байдлыг судлах арга зүйд суралцдаг*
*2.1. Нийгэм, эдийн засгийн макро түвшний үзүүлэлтүүдэд тулгуурлан тэгш бус байдлыг илрүүлэх, нийгэмд үзүүлж буй нөлөөг тодорхойлдог.*
*2.2. Нийгмийн судалгаануудыг бодлого боловсруулахад хэрхэн ашигладаг, бодлого ба тогтолцооны үр дүнгийн баримт нотолгоонд суурилсан шийдвэрлэх арга замыг эрэлхийлдэг.*
*2.3. Боловсролын хүртээмжтэй чанартай үйлчилгээ үзүүлэх арга замыг тодорхойлох, төлөвлөдөг.*
*3.1. Аливаа асуудалд судлаачийн байр сууринаас ханддаг.*
*3.2. Тэгш бус байдлыг бууруулах шийдвэр гаргах, бодлого боловсруулах үйл явцад оролцож манлайлдаг*
*3.3 Боловсрол дахь тэгш оролцоо, шударга, ёс зүйтэй харилцааг дэмждэг*

## 2. Үнэлэх хэлбэр, жин:

***Хүснэгт 1. Үнэлгээний жин, хэлбэр***

| № | Үнэлгээний хэлбэр | Жин | Багтаамж |
|---|---|---|---|
| 1 | Ирц, идэвх оролцоо | 10%, 20% | - Ирцийг бүртгэлээр тооцож харгалзан оноог өгнө.<br>- Идэвх оролцоог багш болон бусад оюутны үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байдлаар тооцно. |
| 2 | Явцын сорил, шалгалтын үнэлгээ | 30%/15+15/ | 2 удаагийн явцын шалгалт авна.<br>- эхний шалгалт хичээлийн агуулгын 50% /VIII долоо хоног/<br>- хоёр дахь шалгалт хичээлийн агуулгын үлдсэн 50% /XIV долоо хоног/ |
| 3 | Бие даалтын үнэлгээ | 40%/15+25/ | 2 удаагийн бие даалт гүйцэтгэнэ.Үүнд:<br>- судалгааны бэлэн материал уншиж, илтгэх |

| | | | |
|---|---|---|---|
| | | | - боловсруулах бие даалт |
| Нийт | | 100% | |

## ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

| | |
|---|---|
| Нэр: | БОЛОВСРОЛЫН ХҮРТЭЭМЖ БА ЧАНАР (ACCESS AND QUALITY OF EDUCATION) |
| Код: | E.EA606 |
| Судлах улирал: | дурын 1:2:0:0(3) |
| Нийт цаг5 | 48 цаг; 2 кредит |
| Багшийн мэдээлэл: | |
| Тэнхимийн нэр: | Боловсрол судлалын сургууль, Боловсролын удирдлага |
| Багшийн нэр, цол зэрэг: | Г.Өлзийсайхан, доктор |
| Утас: | 96040323 |
| Э-шуудангийн хаяг: | ulziisaikhan@msue.edu.mn |
| Зөвлөгөө өгөх гараг, цаг: | Мягмар, пүрэв гараг 14:00-16:00 |
| Цахим хуудас: | |

**Үндсэн сурах бичиг:**

*Sahek, D. R. A., & Nasri, N. B. M. (2019). A Systematic Review: Access Equality towards Quality Education. Creative Education, 10, 2947-2954. https://doi.org/10.4236/ce.2019.1012219*

*Goldin, Claudia and Lawrence F. Katz. 2007. The Race Between Education and Technology (Chapter 8). Harvard University Press. https://www.nber.org/system/files/working_papers/w12984/w12984.pdf*

*P. Attewell & K. S. Newman (2010). Growing Gaps: Educational Inequality Around the World. n. Oxford University Press.*

*Richard B. Freeman. (2002). Inequality Around the World. International Economic Association 2002.*

*United Nations Economic and Social Commission for Asia and the Pacific. (2017). Inequality of Opportunity in Asia and the Pacific: Education*

*Jo Blanden, Matthias Doepke, Jan Stuhler. (2022). Educational Inequality. The IZA Institute of Labor Economics.*

***Нэмэлт судлах материал:***

*Otgontugs. B., Suguru. M., & M. Bayarjargal. (2019). Education inequality in Mongolia: Measurement and causes.* International Journal of Educational Development, Volume 68*, July 2019, 68-79.*

*UNESCO. (2020). Global Education Monitoring Report 2020: Inclusion and education: All means all. Paris, UNESCO.*

*Нарантуяа. Д.(2021). "Тэгш бус байдал"-ын тухай тэмдэглэл ба бодлогын зөвлөмж. http://library.fes.de/pdf-files/bueros/mongolei/17333.pdf*

*ҮСХ. (2018). Эдийн засгийн өсөлт, ядуурал, ажилгүйдлийн хамаарлын судалгаа.*

*ҮСХ. (2020). Боловсрол ба хөдөлмөр эрхлэлт.*

*Ж.Ариунболд, Б.Басбаяр. (2021). Ирээдүйн хөдөлмөр эрхлэлт ба боловсролын бодлогын уялдаа.*

*Emma García & Elaine Weiss (2017). Education inequalities at the school starting gate. Gaps, trends, and strategies to address them. Economic policy institute. Washington, DC.*
*Prepared by Era Dabla-Norris, Kalpana Kochhar, Frantisek Ricka, Nujin Suphaphiphat, and Evridiki Tsounta. (2015). Causes and Consequences of Income Inequality: A Global Perspective. INTERNATIONAL MONETARY FUND.*
*ILO. (2016), Эрх тэгш байдлыг дэмжих. Адил тэгш цалин хөлсний хүйсээс үл хамаарах ажлын байрны үнэлгээ. https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/---ro-bangkok/---ilo-beijing/documents/publication/wcms_464251.pdf*
*OECD. (2011). Divided We Stand: Why Inequality Keeps Rising. (Executive Summary). And a 2016 update on income inequality:*
*OECD. (2016). "Income inequality remains high in the face of a weak recovery".*
*Карин Шелциг, Кирсти Ньюман. (2020). Монгол улсад тэгш хамруулах боловсролыг дэмжих нь. https://www.adb.org/sites/default/files/publication/720336/eawp-28-inclusive-education-mongolia-mn.pdf*
*(2020). Монгол улс дахь хүүхдийн эрхийн нөхцөл байдлын үнэлгээ*
*https://environmental-conscience.com/lack-of-education-causes-effects-solutions/*
*https://ourworldindata.org/global-education*
*Anja K.Leista., Eyal Bar-Haimb., LouisChauvel. (2021). Inequality of educational opportunity at time of schooling predicts cognitive functioning in later adulthood. SSM - Population Health, Volume 15.*

**Хичээлийн өмнөх холбоо:** E.EA501

**Хичээлийн товч тодорхойлолт:** Энэхүү хичээл нь эдийн засаг, нийгмийн тэгш бус байдлын талаар ялангуяа боловсролын тэгш байдал, түүний шалтгаан үр дагаврыг судлах болно.

**Хичээлийн зорилго:** Тэгш бус байдлын шалтгаан ба үр дагаврын талаарх нийгмийн ухааны тайлбар, чиг хандлагад суралцах, тэгш бус байдлын үр дагаврыг хэлэлцэх зэрэг бөгөөд нийтлэг арга зүй, хүрээнд суралцах, улс, орон нутгийн тодорхой бодлогуудад тэгш бус байдлыг үүсгэдэг нийгмийн хүчнүүд хэрхэн уялдааг ойлгох

***Хүснэгт 2. Хичээлээр эзэмших мэдлэг, чадвар ба хичээлийн агуулгын хамаарал***

| Бүлэг | | Хичээлээр эзэмших мэдлэг, чадвар |
|---|---|---|
| Боловсролын удирдлагын онол | Менежментийн онолууд, тэдгээрийн боловсрол дахь хэрэглээ | (1.1), (1.2), (2.1), (2.2) |
| Сургуулийн хамт болон | Багшийн ажлын мотиваци, удирдах ажилтны манлайлал | (2.1), (2.2), (2.3) |
| Сургуулийн бүтэц | Сургуулийн дэд бүтцүүдийн онцлог | (2.1), (2.2), (2.3) |

***Хүснэгт 3. Хичээлийн жишиг төлөвлөгөө***

| Дд | Сэдэв | Судлах цаг | |
|---|---|---|---|
| | | Лек | Семинар |

| | | ц | |
|---|---|---|---|
| 1. | Тэгш байдлын талаарх онол үзэл баримтлал | 2 | 4 |
| 2. | Тэгш бус байдал ба үе хоорондын хувирамтгай чанар Normative Dimensions of Inequality and Intergenerational Mobility | 2 | 4 |
| 3. | Боловсрол ба ур чадвар – Макро хэтийн төлөв<br>Education and Skills – Macro Perspective | 2 | 4 |
| 4. | Боловсролын байгууллага<br>Educational Institutions – Preschool, school | 2 | 4 |
| 5. | Боловсролын байгууллага<br>Educational Institutions –Higher Education | 2 | 4 |
| 6. | Хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалт – ҮЭ, Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ,<br>Labor Market Institutions – Unions, Minimum Wage and Worker Bargaining Power | 2 | 4 |
| 7. | Тэгш бус байдал ба улс төр – хэвлэл мэдээлэл, мөнгө<br>The Politics of Inequality – Elite Influence, Mass Media and Money in Politics | 2 | 4 |
| 8. | Тэгш бус байдал ба ирээдүй<br>The Future of Inequality – A World Without Work? | 2 | 4 |
| Нийт | | **16** | **32** |

***Арга зүй***: Багш ерөнхий мэдээллийг өгч, оюутнууд бодит жишээгээр баяжуулан, боловсролын нийгэм, сэтгэл зүйн үзэгдлүүдээс удирдлагын ухааны асуудлууд, тэдгээрт хамаарах судалгааны хувьсагч зэргийг эрэлхийлж гаргана. Хичээлийн явцад бие даан асуудал шийдвэрлэх, хамтран ажиллах арга зүйд тулгуурлан судалгаануудад дүн шинжилгээ хийх, сургалтын арга зүйд суралцах нөхцөлийг бүрдүүлнэ.

***Үнэлгээ***: Суралцагч нэг бүрийн идэвх оролцоог тооцсон, суралцагчийн менежментийн онолын хэрэглээний ахисан түвшний мэдлэг, чадвар, хандлагад гарч буй ахиц дэвшлийг МУБИС-ийн суралцагчийн үнэлэх журмын дагуу үнэлнэ.
Хичээлд суусан/оролцсон байдлыг үнэлэх арга:
Хичээлийн ирц ба оролцоо 30% байх ба 10% нь ирц, 20% нь семинарын хичээлийн хэлэлцүүлэгт оролцож буй байдлаар тодорхойлогдоно. Семинарын хичээлээр хэлэлцэх материалыг багш урьдчилан бэлтгэсэн байна.
Оюутны олж авсан мэдлэг чадварыг шалгах:
Шалгалтын үнэлгээ нь 30 оноо байх ба 7, 14-р долоо хоногт шалгалтыг сорил тестээр авах ба тус бүр 15 оноотой байна.

Бие даалтын даалгаврыг үнэлэх арга: Гүйцэтгэх, боловсруулах 2 төрлийн бие даалтыг тус бүр нэг удаа өгнө. Гүйцэтгэх даалгавар 15, боловсруулах даалгавар 25 оноотой байна. Оюутан тус бүрийн бие даалтын сэдэв давхцахгүй байна.

**Бие даалт 1. УДИРДАМЖ**

*Сэдэв:* Эдийн засаг, нийгмийн салбарт илэрч буй тэгш бус байдлыг сонгон энэ нь боловсролд хэрхэн шалтгаан, үр дагавар болж илэрч буй талаар өөрийн санаа бодлогыг бичих.

*Хэлбэр*: Бичвэр

*Хугацаа*: X долоо хоног

*Зорилго*: Асуудлыг гаргаж ирэх, өөрийн бодлогын бичвэрээр илэрхийлэх, хичээлийн агуулгыг бататгах, хэрэглэх

*Шалгуур*:

1. Хугацаа 10 оноо /тогтоосон хугацаанаас 2 хоногийн хойно өгөхийг зөвшөөрнө. Хоног бүрт 3 оноо хасна/
2. Асуудлыг зөв илрүүлсэн эсэх 20 оноо
2. Боловсролтой уялдуулж чадсан эсэх 20
3. Логик уялдаатай бичсэн эсэх 40 оноо
4. Өгөгдсөн стандартын дагуу бичсэн эсэх 10

*Бие даалтын загвар*: Үүнд: А4-ын хэмжээтэй (Тусад нь нүүр, хавтас хийх шаардлагагүй. Өгүүллийн хуулбарыг хавсаргасан байна.) Файлын нэрийг Оюутны нэр, кодоор өгнө. Жнь: Өлзийсайхан Е.ЕМ21Е103

Бие даалтын илтгэлийн материалд дараах зүйлсийг заавал багтаан, доорх загвар, стандартын дагуу бичнэ.

---

Сэдэв

он сар өдөр оюутны нэр (код)

Эдийн засаг, нийгмийн .....

---

- Үсгийн фонт, хэмжээ: Times New Roman-11,
- Мөр хоорондын зай: At least 11pt, догол мөр 0.5см
- Бүлэг, дэд бүлгийн гарчгийг догол мөрнөөс bold-р бичнэ.
- Хуудасны хэмжээ: A4, top 2cm, bottom 2cm, right 2cm, left 2cm
- Хүснэгт: хүснэгтийн гарчиг баруун дээд хэсэгт, үсгийн хэмжээ 11, хүснэгт дэх агуулгын үсгийн хэмжээ 10pt өндөртэй
- Зураг: зургийн гарчиг доод төв хэсэгт, үсгийн хэмжээ 11
- Ишлэл, зүүлт, ном зүй: APA style-ийн дагуу (бие даан судлах)

**Бие даалт 2. УДИРДАМЖ**

*Сэдэв:* Боловсрол нэг бодлого сонгон авч тэгш бус байдлын талаар өөрийн санал бодлыг бичих

*Хэлбэр*: Боловсруулах

*Хугацаа*: хичээл дууссаны дараа 1 долоо хоног
*Зорилго*: Судалгааны арга зүйд суралцах
*Арга зүй*:

- Хичээлийн агуулгатай холбоотой нэг агуулгыг сонгон авч түүнийг Монголын боловсролын асуудалтай холбон анализ, дүгнэлт хийж paper бичиж хураалгана.
- Сонгосон сэдвээ урьдчилан багшдаа мэдэгдэх бөгөөд илтгэлийн өмнө заавал багшаас зөвлөгөө авсан байна.
- Өөрийн санааг тодорхой гарсан байхаар дэс дараатай, шүүмжлэлт байдлаар бичнэ.
- Paper нь удиртгал (зорилго), үндсэн хэсэг (онолын хэсэг), арга зүй, хүлээж буй үр дүн гэсэн агуулгаар бичигдсэн байна.
- А4-ийн хэмжээтэй 5-10 хуудсанд багтаан бичнэ.

*Зорилго*: Судалгааны ажлын арга барилд суралцах, хичээлийн агуулгыг бататгах
*Үйл явц*:

- Сэдвээ сонгох
- Материал судлах, эх сурвалж хайх
- Боловсруулах
- Бичвэр бичих

*Шалгуур*:

- Тогтоосон хугацаанд өгсөн эсэх /10 оноо/
- Сэдвээ зөв тодорхойлсон эсэх /10 оноо/
- Зорилгоо тодорхой гаргаж өгсөн эсэх /10 оноо/
- Онолын хэсгийг судалсан байдал /20 оноо/
- Арга зүйгээ тодорхой гаргасан эсэх /10 оноо/
- Сэдэв, зорилго, арга зүй хоорондоо уялдаатай эсэх /10 оноо/
- Судалсан материал /10 оноо/
- Хүлээж буй үр дүнг тодорхойлж бичсэн эсэх /10 оноо/
- Судалгааны ажлын загвар, стандарт хангасан байдал /10 оноо/

*Feedback*:

Багш даалгаврыг хүлээн авсны дараа 14 хоногийн дотор хариу зөвлөмжийг бичиж, и-мэйлээр хариу явуулна (Хичээлийн эцсийн дүнгийн хамт).

*Term paper бичих загвар*:

А4-ын хэмжээтэй цаасан дээр бичнэ. Багшийн e-mail хаягаар ирүүлнэ. Илгээхдээ file-ийн нэрийг оюутан өөрийн нэр, овгийн эхний үсгийн хамт галиглаж бичнэ. Жишээ нь Ulziisaikhan. G.

Бичвэрийг дараах загвар, стандартыг баримталж бичнэ.

---

Судалгааны ажлын нэр

он сар өдөр оюутны нэр (код)

*Судалгааны зорилго* (уг сэдэв яагаад чухал болох, тэгвэл энэ судалгаа ямар зорилго дэвшүүлж байгаа, энэ зорилгод хүрэхийн тулд ямар судалгааны асуулт дэвшүүлсэн)............

*Онолын хэсэг* (Судалгааны зорилгод хүрэх шаардлагатай мэдээлэлтэй

---

ажиллаж чадсан байх)
*Судалгааны арга зүй* (Судалгааны явц, түүврийн сонголт, судалгааны багаж боловсруулах тухай, үр дүнг хэрхэн боловсруулах)............
Судалгааны хүлээгдэж буй үр дүн ...........
Ном зүй...............

- Үсгийн фонт, хэмжээ: Times New Roman-11,
- Мөр хоорондын зай: At least 11pt, догол мөр 0.5см
- Бүлэг, дэд бүлгийн гарчгийг догол мөрнөөс bold-р бичнэ.
- Хуудасны хэмжээ: A4, top 2cm, bottom 2cm, right 2cm, left 2cm
- Хүснэгт: хүснэгтийн гарчиг баруун дээд хэсэгт, үсгийн хэмжээ 11, хүснэгт дэх агуулгын үсгийн хэмжээ 10pt өндөртэй
- Зураг: зургийн гарчиг доод төв хэсэгт, үсгийн хэмжээ 11
- Ишлэл, зүүлт, ном зүй: APA style-ийн дагуу (бие даан судлах)